



НИЙГЭМ
УЛС ТӨРИЙН
БОЛОВСРОЛ

НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ
ТӨРИЙН БҮС БАЙГУУЛЛАГА

ЗҮЕИЙН ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

/17-26 нас/

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2021



“ZVOTE” төслийн хүрээнд энэхүү
судалгааг хийж гүйцэтгэв.

Хамтрагч байгууллагууд:
Конрад - Аденауэр - Сан
Нийгэм улс төрийн боловсрол НҮТББ
Хугацаа: 2021.05.01 - 2021.06.30

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Конрад Аденауэр Санд талархал илэрхийлье. Түүнчлэн бидний судалгаанд цаг заваа харамгүй зориулан үзэл бодлоо хуваалцсан ахлах ангийн сурагчид, МСҮТ болон их, дээд сургуулийн оюутнууд, төгсөгчид, залуучууд, тэднийг судалгаанд хамруулахад холбож өгсөн сургуулийн удирдлагууд, багш нар, эцэг эхчүүд, гэр бүлийнхэнд гүнээ талархал илэрхийлж байна.

Судалгааны асуулга болон үр дүн, дүгнэлт, санал зэрэг нь зөвхөн тухайн багийн судалгааны үр дүн бөгөөд Конрад Аденауэр Сан албан ёсны байр суурь, бодлогоор нөлөөлөөгүй болно.

Судалгааны багийн бүрэлдэхүүн

Судалгааны багийн ахлагч:

- Б.Эрдэнэдалай, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын гүйцэтгэх захирал, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

Судалгааны багийн зөвлөх:

- Д.Оюунчимэг, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Судалгааны багийн гишүүд:

- О.Батзаяа, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын ахлах судлаач, улс төр судлалын магистрант
- Б.Сайханбаяр, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын судлаач, улс төр судлалын магистр
- Б.Номин, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын судлаач, улс төр судлалын магистр
- Б.Гэрэлмаа, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын судлаач
- Г.Мөнхтуяа, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын судлаач
- Б.Сарантуяа, “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ-ын судлаач

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	8
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ	9
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТҮҮВЭР	11
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	12
1.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	13
1.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР	14
ХОЁР. ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ХЭЛБЭР	16
2.1 СУДАЛГААНД ОРОЛЦСОН ЗАЛУУЧУУДЫН ХҮН АМ, ӨРХИЙН ШИНЖ БАЙДАЛ	17
2.2 ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХЭЛБЭРҮҮД	23
2.3 ЗАЛУУЧУУДЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ОРОЛЦОО, ХАНДЛАГА	32
2.4 ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВДАГ ЭХ СУРВАЛЖ, СУВАГ	43
ГУРАВ. ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ	51
3.1 УЛС ТӨРИЙН СТАТУСААС ХАМААРСАН ХАМААРАЛ	52
3.2 СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД УХУУЛАГЧААР АЖИЛЛАЖ БАЙСАН ЭСЭХЭЭС ХАМААРСАН ХАМААРАЛ	60
3.3 СОНГУУЛИЙГ ЧУХАЛЧИЛДАГ ЭСЭХИЙН ХАМААРАЛ	62
3.4 СОНГУУЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ АВДАГ БАЙДЛЫН ХАМААРАЛ	65
3.5 СОНГУУЛЬД САНАЛ ӨГӨХДӨӨ ЧУХАЛЧИЛДАГ ЗҮЙЛСИЙН ХАМААРАЛ	68
3.6 СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ УНШДАГ ЭСЭХИЙН ХАМААРАЛ	71
3.7 2021 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЭСЭХИЙН ХАМААРАЛ	74
3.8 УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ БАЙДЛЫН ХАМААРАЛ	76
3.9 ОЙР ДОТНЫ ХҮМҮҮСТЭЙГЭЭ УЛС ТӨРИЙН ТАЛААР САНАЛ СОЛИЛЦДОГ БАЙДЛЫН ХАМААРАЛ	79
3.10 УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ СОНИРХОХ БАЙДЛЫН ХАМААРАЛ	81
3.11 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ УЛС ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ БАЙДЛЫН ХАМААРАЛ	83
3.12 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО	85
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	89



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Судалгаанд оролцогчдын нас
- Зураг 2. Судалгаанд оролцогчдын хүйс
- Зураг 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин
- Зураг 4. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт
- Зураг 5. Судалгаанд оролцогчдын амьжиргааны түвшин
- Зураг 6. Судалгаанд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй эсэх
- Зураг 7. Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршил
- Зураг 8. Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршил, дэлгэрэнгүй
- Зураг 9. Улс төр сонирхдог эсэх
- Зураг 10. Улс төрийн оролцоо
- Зураг 11. Улс төрийн статусын байдал
- Зураг 12. Сонгуулийн сурталчилгаанд ухуулагчаар ажиллаж байсан эсэх
- Зураг 13. Ухуулагчаар ажилласан бол тухайн нам, нэр дэвшигчид саналаа өгсөн эсэх
- Зураг 14. Өнөөгийн улс төрийн байдлыг үнэлсэн үнэлгээ
- Зураг 15. Сонгуульд оролцох нь чухал эсэх
- Зураг 16. Сонгуулийн талаарх ойлголт
- Зураг 17. Сонгуульд оролцож байсан туршлага
- Зураг 18. Сонгуульд оролцох нас хүрсэн ч, саналаа өгч байгаагүй шалтгаан
- Зураг 19. 2020 онд болж өнгөрсөн сонгуулиуд шударга, зөв болсон эсэх
- Зураг 20. Сонгуульд санал өгөхөд чухалчилдаг хүчин зүйлс
- Зураг 21. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг эсэх
- Зураг 22. Монгол Улсыг удирдах хүний шинж
- Зураг 23. Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх эсэх (2021.06.09)
- Зураг 24. Улс төрийн мэдээллийн хүртээмж
- Зураг 25. Улс төрийн талаарх зарим сэдвүүдийг сонирхдог эсэх
- Зураг 26. Цахим орчинд гарч ирдэг улс төрийн талаарх мэдээлэлд хандах байдал
- Зураг 27. Улс төрийн албан тушаалтнуудыг таньдаг эсэх
- Зураг 28. Улс төрийн байгууллагуудад залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байгаа эсэх
- Зураг 29. Цахим орчин дахь хаяг, хамгийн түгээмэл хэрэглэдэг суваг
- Зураг 30. Улс төрийн статус, улс төр сонирхох байдлын хамаарал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 31. Улс төр сонирхох түвшин, улс төрийн статусаар
- Зураг 32. Улс төрийн оролцоо, улс төрийн статусаар
- Зураг 33. Улс төрийн оролцоо бүрийн дундаж, улс төрийн статусаар
- Зураг 34. Улс төрийн оролцоо, улс төрийн статусаар
- Зураг 35. Сонгуульд оролцох чухал эсэх, улс төрийн статусаар
- Зураг 36. Сонгуулийн ухуулагчаар ажиллаж байсан эсэх, улс төрийн статусаар
- Зураг 37. Сонгуулийн санал авах өдөр, бүртгэлтэй холбоотой мэдээлэл, улс төрийн статусаар
- Зураг 38. Нэр дэвшигчтэй холбоотой мэдээлэл олж авах байдал, улс төрийн статусаар
- Зураг 39. Санал өгөх үйл явц ба шийдвэр гаргалтын мэдээлэл, улс төрийн статусаар
- Зураг 40. Нийт улс төрийн мэдээллийн хүртээмж, улс төрийн статусаар, дундаж
- Зураг 41. Ухуулагчаар ажиллаж байсан эсэх, хүйсээр
- Зураг 42. Ухуулагчаар ажиллаж байсан эсэх, насаар
- Зураг 43. Ухуулагчаар ажиллаж байсан эсэх, байршлаар
- Зураг 44. Сонгуулийг чухалчилдаг эсэх, хүйсээр
- Зураг 45. Сонгуулийг чухалчилдаг эсэх, байршлаар
- Зураг 46. Сонгуулийг чухалчилдаг эсэх, насаар
- Зураг 47. Сонгуулийг чухалчилдаг эсэх, сонгуульд оролцож саналаа өгөх эсэх
- Зураг 48. Сонгуулийг чухалчилдаг эсэх, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог байдал
- Зураг 49. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, насаар
- Зураг 50. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, хүйс, байршлаар
- Зураг 51. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, улс төрийн оролцоогоор
- Зураг 52. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал сонгуульд санал өгсөн эсэх
- Зураг 53. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх эсэх
- Зураг 54. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог эсэх
- Зураг 55. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг хүчин зүйлс, хүйсээр
- Зураг 56. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг хүчин зүйлс, байршлаар
- Зураг 57. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншдаг эсэх, хүйсээр

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 58. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг эсэх, байршлаар
- Зураг 59. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх эсэх, нас, хүйс, байршлаар
- Зураг 60. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эсэх, сонголтод чухалчилдаг хүчин зүйлс
- Зураг 61. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эсэх, мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг байдал
- Зураг 62. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, хүйсээр
- Зураг 63. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, байршлаар
- Зураг 64. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог эсэх
- Зураг 65. Улс төрийн талаар санал солилцдог бүлэг, насаар
- Зураг 66. Улс төрийн талаар санал солилцдог бүлэг, хүйс, байршлаар
- Зураг 67. Ойр дотны хүмүүстэй улс төрийн талаар мэдээлэл солилцдог байдал, мэдээллийн хүртээмжээр
- Зураг 68. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог эсэх, мэдээллийн хүртээмжээр
- Зураг 69. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог эсэх, насаар
- Зураг 70. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог эсэх, хүйсээр
- Зураг 71. Цахим орчинд гарсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл, насаар
- Зураг 72. Цахим орчинд гарсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл, хүйсээр
- Зураг 73. Цахим орчинд гарсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл, байршлаар
- Зураг 74. Улс төрийн оролцоо (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд)
- Зураг 75. Сонгуулийг чухалчилдаг эсэх (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд)
- Зураг 76. Сонгуульд оролцож санал өгч байсан эсэх (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд)
- Зураг 77. 2020 онд болж өнгөрсөн сонгуулиуд шударга, зөв болсон эсэх
- Зураг 78. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг эсэх (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд)
- Зураг 79. Цахим орчинд гарсан улс төрийн талаарх мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд)
- Зураг 80. Зарим үзүүлэлтийн харьцуулалт (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд)

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Монгол Улсын 17-26 насны залуучуудын сонгуульд оролцсон тоо
- Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршил. Аймаг, дүүргээр
- Хүснэгт 3. Сонирхдог улс төрийн шийдвэр, үйл ажиллагаа, дэлгэрэнгүй
- Хүснэгт 4. Улс төрд оролцож буй хэлбэрүүд
- Хүснэгт 5. Сонгуулийн талаарх мэдээлэл авдаг байдал
- Хүснэгт 6. Улс төрийн талаарх мэдээллийн эх сурвалж
- Хүснэгт 7. Улс төрийн асуудлаар санал солилцдог байдал
- Хүснэгт 8. Сонгуулийн зарим ойлголтуудын талаарх мэдлэг
- Хүснэгт 9. Зарим зүйлсэд цаг зарцуулах байдал
- Хүснэгт 10. Улс төрийн статустай залуучуудын улс төрийн сонирхол, дэлгэрэнгүй
- Хүснэгт 11. Сонгуулийг чухалчилдаг эсэх, сонгууль өгөх давтамж
- Хүснэгт 12. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг/чухалчлах хүчин зүйлс, насаар
- Хүснэгт 13. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг хүчин зүйлс, гэр бүл ойр дотны хүмүүстэйгээ санал сонилцдог эсэх
- Хүснэгт 14. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншдаг эсэх, насаар
- Хүснэгт 15. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, насаар

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

1996-2012 онд төрөгсдийг олон улсад “Generation Z” буюу “Z үеийнхэн” хэмээдэг. Өндөр технологийн үед өсөн торниж буй тэд өмнөх үеийнхнээсээ эрс ялгаатай байдлаараа судлаачид, мэргэжилтнүүдийн анхаарлыг олон талаар татаж, хэдийн “судлагдахуун” болсон билээ.

2021 оны байдлаар Монгол Улсын нийт сонгогчийн 23 хувийг “Z” үеийнхэн бүрдүүлж байна. УИХ-ын 2012 оны сонгуульд 18-35 насны залуучуудын 60 хувь нь саналаа өгөөгүй бөгөөд санал хураалтад оролцсон сонгогчдын 10 хувь нь 18-25, 25 хувь нь 18-35 насныхан байв. УИХ-ын 2016 оны сонгуульд 18-25 насны залуу сонгогчдын ирц 50.8 хувь, УИХ-ын 2020 оны сонгуульд 62 хувийн ирцтэй оролцсон юм. Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулиас харахад, 20-24 насныхны ирц хамгийн бага байна. Залуучууд бусад насныхнаас 8.3 хувиар доогуур ирцтэй байлаа.

Манай улсад төдийгүй олон улсад сонгогчдын ирц буурч, тэр дундаа залуучуудын оролцоо багасч буй нийтлэг дүр зураг ажиглагдаж байгаа. Нөгөө талаас анх удаа сонгуульд саналаа өгч буй залуучууд ч цэвэр өөрийн итгэл үнэмшлээр, бусдын нөлөө, дарамтаас ангид сонгох эрхээ эдэлж байгаа

эсэх нь эргэлзээтэй. Харин залуучуудын сонгуулийн ирц тааруу байгаад, яагаад гэдэгт хариулах тодорхой үндэслэл, нэгдсэн байр суурь төдийлөн алга байна гэхэд болно. Тиймээс ч тэдний сонгуулийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн аливаа арга хэмжээ, нөлөөллийн ажил хангалттай үр дүнд хүрч чадахгүй байгааг үгүйсгэхгүй.

Хэдийгээр сонгуулийн санал хураалтад оролцох, сонгох, сонгогдох эрхээ эдлэх, аль нэг улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжих, эс дэмжих, түүнийгээ илэрхийлэх нь иргэний улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр, тод илрэл ч зөвхөн үүгээр “Z” үеийнхний онцлогийг тодорхойлох нь өрөөсгөл. Тэр тусмаа мэдээлэл, технологийн эрин үеийн өнгө төрх болж буй 18-25 насныхны улс төрийн оролцоог зөвхөн сонгуулийн идэвхээр төлөөлүүлэн тодорхойлох нь явцуу хэрэг. Нөгөө талаас залуучуудын улс төрийн оролцооны талаарх хараат бус, үндэсний хэмжээний судалгаа сүүлийн жилүүдэд цөөн хийгдсэн. 2016 онд Конрад Аденауэр сангийн дэмжлэгээр Удирдлагын академийн багш, судлаачдын гүйцэтгэсэн “Залуучуудын улс төрийн оролцоо” судалгааг энд нэрлэж болно. Гэхдээ энэхүү судалгаанд 18-35 насны залуучуудыг хамруулсан байдаг.

Залуучуудын улс төрийн болоод сонгуулийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн аливаа сургалт, нөлөөллийн арга хэмжээ нь залуучууд гэсэн ерөнхий бүлэгт ихэвчлэн чиглэж ирсэн гэхэд болно. Өөрөөр хэлбэл, анх удаа саналаа өгч буй шинэ сонгогчдын улс төрийн оролцоо төдийгүй улс төрийн мэдлэг, хандлагыг нь тухайлан тодорхойлох шаардлага хэдийн үүсээд зогсохгүй “Z” үеийнхэнд зориулсан нөлөөллийн ажлууд орхигдож ирснийг анхаарах цаг үе ирээд

байна. Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулиас харахад залуу сонгогчдын бүлэг дотроо 18-19 насныхны ирц харьцангуй өндөр буюу 56.4 хувьтай байгаа нь тэдэнд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ үр дүн өгч болохыг, цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэн, одоогийн идэвх, оролцоог нь бууруулахгүй, улам нэмэгдүүлэх чиглэлд тасралтгүй ажиллах шаардлагатайг илэрхийлж байна.

1



**СУДАЛГААНЫ
АРГА ЗҮЙ, ТҮҮВЭР**

1.1. Судалгааны зорилго, зорилтууд

Z үеийн залуучуудын (17-26 нас) улс төрийн сонирхол, оролцоо, хандлагыг тодорхойлж, тэдний улс төрийн мэдлэг боловсрол, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааны чиглэлийг гаргах нь энэхүү судалгааны зорилго юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа.

- Залуучуудын улс төр, сонгуулийн оролцооны түвшинг тодорхойлох
- Залуучуудын улс төр, сонгуулийн талаарх зарим ойлголтын байдлыг тодорхойлох
- Залуучуудын сонгуулийн зан үйлд эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд шинжилгээ хийх
- Залуучуудын улс төрийн талаарх мэдээллийг авч буй хэлбэр, сувгийг тодруулах зэрэг болно.

1.2. Судалгааны арга зүй

Судалгааг тоон ба чанарын судалгааны арга зүйг ашиглан явууллаа. 17 - 26 насны залуучуудыг судалгаанд хамруулахдаа, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, МСҮТ-ийн суралцагсад, Их, дээд сургуулийн оюутнууд, төгсөөд ажиллаж байгаа болон ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа залуучууд гэсэн ангилал үүсгэн хамрууллаа. Ингэхдээ нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засаг, инженер, анагаах ухаан, спорт зэрэг бүх салбарын залуучуудыг хамруулахыг зорьсон.

Тоон судалгаа: Судалгааны түүврийн дагуу улсын хэмжээнд буюу Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн төлөөллийг оролцуулан нийт 1161 оролцогчоос судалгааны үндсэн мэдээллийг цуглууллаа.

Чанарын судалгаа: 7-10 оролцогч бүхий 5 бүлэг тус бүрээс фокус бүлгийн ярилцлагын аргаар, 8 оролцогчоос ганцаарчилсан ярилцлагын аргаар тус тус судалгаа авч тоон судалгааны мэдээллээ тодотгосон болно.

Асуулгын бүтэц: Энэхүү судалгааны асуулгыг 2016 онд Конрад Аденауэр Сангийн дэмжлэгтэйгээр Удирдлагын Академийн багш, судлаачдын хийж гүйцэтгэсэн “Залуучуудын улс төрийн

оролцоо /18-35 нас/” судалгааны асуулт, агуулга дээр үндэслэн, арга зүйн хувьд 17-26 насны залуучуудад тохируулан, агуулгын хувьд дэлгэрүүлэн боловсруулсан.

Мөн дээрх 2016 оны судалгаанаас ялгаатай нь шинэ сонгогчид буюу зөвхөн “Z үе”-ийн (17 -26 нас) залуучуудын улс төрийн мэдлэг, улс төрийн оролцооны түвшин, хандлага, улс төрийн болон бусад мэдээллийг хүлээн авдаг суваг зэргийг тодорхойлов. Нийт 5 бүлэг, 43 асуулт бүхий санал асуулгын хуудас боловсруулж, онлайнаар Kobotoolbox.org программыг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулав.

1.3. Судалгааны хамрах хүрээ, түүвэр

Хамрах хүрээ

Дэлхий нийтээр “Ковид-19” цар тахлын нөхцөл байдал буюу хөл хорионы дэглэмийг баримтлах шаардлага үүссэнтэй холбоотойгоор судалгаанд оролцогчдоос онлайнгаар судалгаа авч, мэдээлэл цуглуулсан. Монгол Улсын интернэт хэрэглэгчдийн тоо 2.1 сая болсон, мөн 17-26 насны залуучуудын хувьд гар утас, интернэт нь хамгийн анхдагч хэрэглээ болсон бөгөөд энэ цагт судалгааг онлайнгаар авахад ямар нэг хүндрэл учраагүй болно.

Энэхүү судалгаа УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны сонгуулийн дараа, Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн өмнөхөн, сонгуулийн сурталчилгааны буюу улс төрийн идэвх өрнөлтэй цаг үед хийгдсэн учраас улс төрийг сонирхох байдал, улс төрийн оролцооны түвшинд нөлөөлсөн байх магадлалтай.

Түүвэр

Үндэсний Статистикийн хорооны 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн мэдээлэлд үндэслэн, судалгааны эх олонлогийг 470.023

гэжтооцож, судалгааны түүвэрлэлтийн алдааны нарийвчлал ± 3 хувь байхаар, үнэмшлийн түвшин 95 хувийн магадлалтайгаар тооцоход асуулгын аргаар судалгаа авах оролцогчдын тоо буюу түүврийн хэмжээ 1161 болов. Судалгааны чанарын арга буюу ганцаарчилсан ярилцлагын аргаар 8 оролцогчоос, фокус бүлгийн ярилцлагын аргаар 7-10 оролцогч бүхий 5 удаагийн ярилцлагыг хийж нийт 54 оролцогчоос чанарын судалгааны мэдээллийг цуглуулав. Ийнхүү уг судалгааны хүрээнд тоон болон чанарын судалгаанд “Z үе”-ийн (17 -26 нас) нийт 1215 залуучууд хамрагдлаа.

Тоон болон чанарын судалгааны түүврийг бүрдүүлэхдээ ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, МСҮТ-ийн суралцагсад, нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засаг, инженер, анагаах ухаан, спорт зэрэг бүх салбарын их, дээд сургуулийн оюутнууд, төгсөөд ажиллаж байгаа болон ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа залуучуудыг тус тус хамруулсан, Улаанбаатар болон хөдөө орон нутгийн төлөөллийг оролцуулсан зэрэг нь судалгааны үр дүн бодитой гарахад нөлөөлсөн гэж үзэж байна. Мөн судалгаанд нас, хүйс, боловсрол, орлогын түвшин, ажил эрхлэлт,

хөгжлийн бэрхшээлтэй эсэх гэх мэт бүхий л талын оролцогчдыг хамруулж, эх олонлогийг төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхийг зорьсон болно.

Энэхүү судалгааг 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө авсан учраас 17 настай оролцогчид санал авах өдөр 18 насанд хүрч саналаа өгөх боломжтой тул түүвэрт оруулсан.

Нөгөө талаас тэдний улс төрийн талаарх ойлголт, оролцоо, хандлагыг тодорхойлох хэрэгцээ шаардлага байсан болно. Харин 26 хүртэлх насны оролцогчид нийт 7 удаагийн сонгуульд оролцсон байна. Судалгаанд оролцсон 17-26 насны залуучуудыг хэдэн удаагийн сонгуульд оролцсоныг дараах тооцоогоор гаргалаа.

Хүснэгт 1. Монгол Улсын 17-26 насны залуучуудын сонгуульд оролцсон тоо

Нас	2021 оны Ерөнхийлөгч	2020 оны УИХ, орон нутаг	2017 оны Ерөнхийлөгч	2016 оны УИХ, орон нутаг	2013 оны Ерөнхийлөгч	Сонгуульд оролцсон тоо
17 нас	-	- -	-	- -	-	0
18 нас	+	- -	-	- -	-	1
19 нас	+	+ +	-	- -	-	3
20 нас	+	+ +	-	- -	-	3
21 нас	+	+ +	-	- -	-	3
22 нас	+	+ +	+	- -	-	4
23 нас	+	+ +	+	- -	-	4
24 нас	+	+ +	+	+ +	-	6
25 нас	+	+ +	+	+ +	-	6
26 нас	+	+ +	+	+ +	+	7

*(“+” Санал өгсөн, “-”, Санал өгөх нас болоогүй)

2



**ЗАЛУУЧУУДЫН УЛС
ТӨРИЙН ОРОЛЦОО,
ХЭЛБЭР**


2.1 Судалгаанд оролцсон залуучуудын хүн ам, өрхийн шинж байдал

Судалгааны энэ хэсэгт залуучуудын (17-26 нас) улс төрийн оролцоог тодорхойлоход шаардлагатай мэдээлэл буюу тэдний нас, хүйс, амьдарч буй газар, боловсрол, ажил эрхлэлт, амьжиргааны байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг хүн ам, өрхийн шинж байдлыг судаллаа.

Судалгааны хамрах хүрээ, түүвэр




Нас: Залуучуудын насыг 17-18 нас, 19-22 нас, 23-24 нас, 25-26 нас гэсэн насны дөрвөн бүлэгт хувааж авч үзлээ. Судалгаанд оролцсон залуучуудын 68 хувь нь 19-22 насныхан, 25 хувь нь 23-26 насныхан, 18 хувь нь 17-18 насныхан байна.



Зураг 1. Судалгаанд оролцогчдын нас



Хүйс: Судалгаанд оролцсон залуучуудын 59 хувь нь эмэгтэй, 41 хувь нь эрэгтэйчүүд байна.




Зураг 2. Судалгаанд оролцогчдын хүйс




Боловсрол. Судалгаанд оролцсон залуучуудын 48.8 хувь нь дээд, 48.1 хувь нь бүрэн дунд, 2.9 хувь нь бүрэн бус дунд, 0.2 хувь нь бага боловсролтой залуучууд байлаа.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Ажил эрхлэлт. Судалгааны зорилтот бүлэг 17-26 насны залуучууд байсан тул түүврийн 92 хувь нь ахлах сургуулийн сурагч, их, дээд сургуулийн оюутан болон ажил эрхэлдэг залуучууд байв. Бусад ангилалд хамаарах оролцогчдын хувьд сайн дурын ажил эрхэлдэг, ахлах сургуулиа төгсөөд завсарлага авч буй сурагчид, хүүхдээ хараад гэртээ байдаг, өвчтэй зэрэг шалтгаан бүхий оролцогчид байлаа.


Зураг 4. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт






Амьжиргааны түвшин. Судалгаанд оролцогчдын 69 хувь нь өрхийн орлого амьжиргааны түвшинд “хангалттай хүрэлцдэг”, “боломжийн хүрэлцээтэй” гэсэн хариулт өгсөн бол 31 хувь нь “хангалтгүй”, “хүрэлцдэггүй” гэсэн хариултыг өгчээ.

Зураг 5. Судалгаанд оролцогчдын амьжиргааны түвшин



Хөгжлийн бэрхшээлтэй эсэх. Судалгаанд оролцогчдын 3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй залуучууд байлаа. Тэдгээр залуучуудыг бэрхшээлийн төрлүүдээр нь нарийвчлан харвал, 41 хувь нь харааны, 22 хувь нь хэл ярианы, 15 хувь нь хөдөлгөөний, 7 хувь нь сонсголын, үлдсэн 22 хувь нь бусад төрлийн бэрхшээлтэй байв.


Зураг 6. Судалгаанд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй эсэх






Байршил. Судалгаанд оролцсон залуучуудын 59.9 хувь нь нийслэл Улаанбаатар хотоос, 40.1 хувь нь хөдөө, орон нутгаас хамрагдлаа.

Зураг 7. Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршил



Зураг 8. Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршил, дэлгэрэнгүй



**Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын амьдарч
буй байршил: Аймаг, дүүргээр**

Түүвэрт эзлэх хувь	
НИЙСЛЭЛ	59.9%
Баянзүрх дүүрэг	19.7%
Баянгол дүүрэг	10.7%
Хан-Уул дүүрэг	10%
Сонгинохайрхан дүүрэг	8.1%
Сүхбаатар дүүрэг	6.1%
Чингэлтэй дүүрэг	3.9%
Бусад дүүрэг (Налайх, Багануур, Багахангай)	1.3%
АЙМАГ	40.1%
Сүхбаатар аймаг	5.9%
Архангай аймаг	3.9%
Өвөрхангай аймаг	3.8%
Дорнод аймаг	2.7%
Хөвсгөл аймаг	2.5%
Увс аймаг	2.5%
Говь-Алтай аймаг	2.5%
Сэлэнгэ аймаг	2.1%
Ховд аймаг	2.1%
Хэнтий аймаг	1.9%
Баянхонгор аймаг	1.7%
Булган аймаг	1.4%
Завхан аймаг	1.3%
Дорноговь аймаг	1.1%
Өмнөговь аймаг	1%
Дархан-Уул аймаг	1%
Бусад аймаг (Дундговь, Баян-Өлгий, Орхон, Төв, Говьсүмбэр)	2.8%


2.2 ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ХЭЛБЭР

Судалгааны энэ хэсэгт Z үеийн залуучуудын (17-26 нас) улс төрийн оролцоог тодорхойлохдоо тэдний улс төрийн статус, сонирхол, улс төрд ямар хэлбэрээр оролцдог, улс төрийн нөхцөл байдлыг хэрхэн дүгнэж байгааг судаллаа.

*Мөн энэ хэсэгт судалгааны фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын хүрээнд залуучуудын илэрхийлсэн байр суурь, санал бодлыг **ШИГТГЭЭ** болгон орууллаа. Гэхдээ эдгээр **ШИГТГЭЭ** нь энэхүү асуулгын судалгааны үр дүнг батлах эсвэл няцаах зорилго агуулаагүй, судалгаанд оролцсон залуучуудын зарим байр суурь, санал бодол гэдгийг дахин дурдая.*

ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ХЭЛБЭР

Зураг 9. Улс төр сонирхдог эсэх



“Та улс төрийг хэр их сонирхдог вэ” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 12 хувь нь “маш их сонирхдог” гэж хариулсан бол 58 хувь нь “ер нь сонирхдог”, “хааяа сонирхдог” гэж хариулсан байна.



“Улс төрийн талаарх мэдлэгийг анх ЕБС-ын “Нийгмийн тухай мэдлэг” хичээлээсээ суурь мэдлэг сайн олж авсан гэж би боддог. Их сургуульд ороод “Улс төр судлал” хичээлийнхээ хүрээнд илүү гүнзгий ойлголт авч, өөрийн сонирхсон сэдвээрээ бие даалт хийсэн маань надад таалагдсан. Сонгуулийн зарчмуудын талаарх хэрэгжилт манай улсад ямар байгаа талаар анализ хийж байсан. Энэ бүхнээс улс төрийн асуудлуудыг илүү сонирхдог болсон юм.”

Эдийн засагч, эмэгтэй, 25 нас

“ЕБС-д Нийгмийн ухааны мэдлэг хичээлээр улс төрийн талаарх сэдвийг багш “уншаарай” гээд, бид нар шалгалтандаа зориулж уншаад л өнгөрч байсан. Харин их сургуульд ороод “Улс төр судлал” гэсэн хичээл заавал судлах хичээлүүд дунд байсныг үзсэн. Уг нь яг ойлгоод анзаарвал улс төр бидний өдөр тутмын амьдралтай их холбоотой юм байна лээ. Улс төрийн талаар мэдлэгтэй болсноос хойш улс төрийн талаар анзаарч, сонирхох болсон.”

Биологийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 21 нас

“Хамт сурдаг оюутан найзууд улс төр ярьдаггүй, сонирхдоггүй гэж хэлж болно. Оюутны холбооны хэдэн хүүхдүүд л хааяа биелэх боломжгүй эсвэл хошин зүйл ярихаараа “улс төр” хийлээ, ярилаа гэж л ярьдаг. Улс төрийн талаар ойлголт бага. Гэхдээ сонгуульд саналаа өгөх ёстойг бол мэднээ.”

Анагаахын мэргэжлийн оюутан, эрэгтэй, 18 нас

Хүснэгт 3. Сонирхдог улс төрийн шийдвэр, үйл ажиллагаа, дэлгэрэнгүй

	Маш их сонирхдог	Ер нь сонирхдог	Хааяа сонирхдог	Нэг их сонирхдоггүй	Огт сонирхдоггүй
Өдөр тутмын улс төр	11%	27%	33%	20%	9%
Ерөнхийлөгчийн гаргаж буй зарлиг, шийдвэр	9%	32%	36%	17%	6%
УИХ-аас баталж буй хууль, тогтоомжууд	13%	29%	36%	16%	6%
Засгийн газрын гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа	15%	34%	33%	12%	6%
Яам, агентлагаас гарч буй шийдвэр, үйл ажиллагаа	8%	24%	35%	23%	10%
Нийслэл, аймгийн засаг захиргаанаас гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа	7%	23%	33%	25%	12%
Дүүрэг, сумын засаг захиргаанаас гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа	7%	21%	31%	25%	16%
Шүүхийн шийдвэрүүд	7%	17%	30%	26%	20%
Сонгуулийн үр дүн	30%	30%	23%	9%	8%
Бусад	13%	19%	28%	14%	26%

Залуучууд улс төрөөс сонгуулийн дүнг хамгийн их сонирхдог. Улс төрийн шийдвэр гаргах түвшний байгууллагуудаас Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын гаргаж буй мэдээллийг илүү их сонирхдог бол шүүхийн шийдвэрийг хамгийн бага сонирхож байна. Бусад гэсэн хэсэгт бичиж хариулт өгсөн залуучуудын хувьд нийгмийн өмнө тулгамдаад байгаа, цаг үеийн шинжтэй асуудлуудыг сонирхдог гэж тайлбар өгчээ.




“Улс төрийн талаар найз нөхөдтэйгээ ярилцах гэхэд тэд дургүй ханддаг. Эхлээд улс төрийн ойлголтуудыг болон нөхцөл байдлыг тайлбарлаад ярьдаг л даа. Гэхдээ найзууд маань дургүйцээд байдаг учраас яваандаа улс төрийн сэдвээр ярихаа больдог. Уг нь залуучуудад улс төрийн асуудлыг сайн ойлгуулж, тайлбарлаж таниулбал их чухал. Гэхдээ тэдний улс төрд дургүй байхад нь олон зүйл нөлөөлдөг байх.”

Улс төр судлал мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас

“Ковид-19” цар тахал гарснаас хойш улс төрийн асуудлыг хааяа сонирхдог болсон. Яагаад гэвэл, ковидтой холбоотойгоор улс төрчдийн гаргаж буй шийдвэрүүд миний болон гэр бүлийн минь амьдралд шууд нөлөөлж байгаа учраас. Мөн гадны улс орнуудын ковидын эсрэг авч буй арга хэмжээнүүдийг өөрийн орны улс төрийн шийдвэр, үйл ажиллагаануудтай харьцуулж харж байгаа.”

Гадаад хэлний орчуулагчийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 21 нас

Зураг 10. Улс төрийн оролцоо



Өөрийнхөө улс төрийн оролцоог дүгнэх асуултад судалгаанд оролцогчдын 58 хувь нь “зарим үед л оролцдог”, 13 хувь нь “байнга оролцдог” гэсэн бол 15 хувь нь “огт оролцдоггүй” гэж хариулжээ. Судалгааны энэ асуултад нийт оролцогчдын 14 хувь нь “хэлж мэдэхгүй байна” гэсэн хариулыг сонгосон нь улс төрийн оролцоо гэдэг ойлголтыг зарим талаараа мэдэхгүй, эсвэл өөрийнхөө улс төрийн оролцооны түвшинг тодорхойлж үнэлэх байдал тааруу байгааг харуулж болох юм.



“Улс төрийн оролцоо гэдгийг сонгуульд оролцож саналаа өгөх юм байна л гэж ойлгодог. Өөр асуудлуудыг төдийлөн сайн мэдэхгүй байна. Энэ талаарх мэдээлэл манай үеийн залуучуудад тийм сонирхолтой санагддаггүй байхаа.”

Эдийн засгийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 19 нас

“Миний хувьд улс төрийн талаарх ойлголт муу, оролцоотой байх тухай, эсвэл Засгийн газар гэж юуг хэлж байгааг ч ялгаж, салгаж чадахгүй байна. Нас ахихаар улс төрийн амьдралд оролцдог, эсвэл сонирхдог болдог гэж боддог. Манай гэрийнхэн хааяа улс төрийн талаар ярьдаг, сүүлд ковидтой холбоотойгоор улс төрчдийн хийж байгаа ажлуудыг шүүмжилж байсан нь санагдаж байна. Эцэг эх маань надтай улс төрийн талаар цаг гарган ярьж байгаагүй.”

Багш мэргэжлийн оюутан, эрэгтэй, 19 нас

“Сургуулиа төгсөөд ажил дээр гарахаар улс төрийн ерөнхий ойлголтуудаа бол гадарлахтай болсон байдаг. Гэхдээ улс төр миний амьдралд хэзээ, хаана нөлөөлж байна гэдгийг харвал, хийж байгаа ажилтай минь, амьдралтай минь холбогдоод байгаа нь илүү анзаарагддаг. Ялангуяа, улс төрчдийн гаргаж буй шийдвэрүүд ажил, амьдралд минь нөлөөлөөд ирэхээр илүү ойлгодог, илүү сонирхдог болдог юм байна.”


Хүний нөөцийн мэргэжилтэн, эмэгтэй, 25 нас

Хүснэгт 4. Улс төрд оролцож буй хэлбэрүүд

	Байнга	Заримдаа	Огт үгүй	Энэ талаар ойлголт байхгүй
Сонгуульд саналаа өгч оролцож байсан	67%	12%	18%	2%
Фэйсбүүкээр санал бодлоо илэрхийлдэг (**Like** зэрэг эможи дарж хариу үзүүлдэг)	23%	48%	25%	4%
Өөрийн профайл дээрээ **Share** хийж хуваалцдаг, / эсвэл холбогдох группүүд руу Share хийдэг/	10%	32%	51%	7%
Тухайн мэдээ, постын доор **Comment** бичиж сэтгэгдэл үлдээдэг	9%	28%	54%	9%
Твиттерээр санал бодлоо илэрхийлдэг	11%	13%	60%	16%
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр (сонин, сэтгүүл, радио, телевиз гэх мэт) байр сууриа илэрхийлдэг	5%	14%	66%	15%
Цахим платформуудад орж санал бодлоо илэрхийлдэг (улс төрчдийн албан ёсны хуудас, и-мэйл, подкаст, мэдээллийн сайтын сэтгэгдэл хэсэг, орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулга гэх мэт)	6%	26%	57%	11%
Жагсаал, цуглаанд оролцож байсан	6%	19%	60%	15%
Улс төрийн намыг идэвхтэй дэмжиж оролцдог	6%	14%	66%	14%
Улс төрийн намын гишүүнээр элссэн тул оролцдог	5%	10%	68%	17%
Санал хүсэлтээ бичгээр холбогдох газарт хүргүүлж оролцдог	4%	14%	64%	18%
УИХ-ын гишүүний уулзалтад оролцож, саналаа илэрхийлдэг	4%	16%	64%	16%
Амьдарч буй орон нутгийн удирдлагатай /Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал/ уулзаж, санал бодлоо илэрхийлдэг	4%	18%	63%	15%
Улс төрийн намд хандив өгдөг	3%	9%	69%	19%
Сонгуулийн сурталчилгаа, кампанит ажилд ухуулагчаар ажилладаг	5%	19%	62%	14%
Бусад	7%	16%	51%	26%

Залуучуудын улс төрд оролцдог хамгийн түгээмэл хэлбэр нь “сонгуульд саналаа өгөх” байна. Судалгаанд оролцогчдын 79 хувь нь ийнхүү хариулжээ. Үүнээс гадна “фэйсбүүк хуудас дахь мэдээлэлд лайк зэрэг эможи дарж хариу үзүүлдэг” гэсэн оролцооны хэлбэрийг 71 хувь нь сонгожээ. Харин улс төрийн оролцооны бусад хэлбэрүүдэд “огт оролцдоггүй” ба “энэ талаар ойлголт байхгүй” гэсэн хариултаудыг сонгосон хувь нилээд өндөр буюу 88 хүртэлх хувь байна.

Зураг 11. Улс төрийн статусын байдал



Судалгаанд оролцогчдын 84.8 хувь нь улс төрийн ямар нэг статусгүй байсан бол, 13.2 хувь нь улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын гишүүн байсан. Харин бусад гэсэн ангилалд багтах 0.8 хувь нь ийм статуст одоогоор харьяалагддаггүй, сонирхол байхгүй, дунд сургуулийн сурагч зэрэг хариултыг өгчээ. Өөрөөр хэлбэл, энэхүү бусад гэсэн хариултыг нэмбэл судалгаанд оролцогчдын 85.6 хувь нь улс төрийн статусгүй байлаа.




“Сонгуулийн ажил хийж байхдаа тухайн намынхаа гишүүн болж байсан. Манай найзуудын ихэнхийг нь тухайн нам бас элсүүлсэн. Бид тухайн үедээ сонгуульд нь ажиллаж байгаа юм чинь гишүүн болчихёо дөө, дараа нь гарчихаж болно ш дээ гэж ярилцаад улс төрийн намын гишүүн болж байсан. Гэхдээ одоо хүртэл тэр намаасаа гарсан хүн байхгүй л байна.”

Инженерийн мэргэжлийн оюутан, эрэгтэй, 20 нас

“Манай аймгийн оюутны холбооны залуучууд аймгаас сонгогдсон улс төрчдийг бүүр үнэн голоосоо дэмждэг. Сонгууль болохоор, эсвэл сонгуулийн бус үед ч залуучууд руу чиглэсэн спорт, урлагийн тэмцээн уралдаанууд зохиогоод тэндээ олон хүүхэд, залуучууд хамруулна гээд бөөн юм болдог. Миний бодлоор тэр холбооны залуучууд аль нэг улс төрийн намд орох, хэн нэгэн улс төрчийн туслах хийж түүний багт “цүнх баригч” хийж байгаа нь сурсан мэдсэнээ ашиглаж шударгаар хөдөлмөрлөх, хийж бүтээж байгаагаас өөр байдаг.”

Судлаач, эмэгтэй, 26 нас

Зураг 12. Сонгуулийн сурталчилгаанд ухуулагчаар ажиллаж байсан эсэх



Судалгаанд оролцогчдын 71.1 хувь нь сонгуулийн сурталчилгаа, кампанит ажилд ухуулагчаар ажиллаж байгаагүй, харин 28.9 хувь нь ухуулагчаар ажиллаж байсан байна. Тодруулбал, 3 залуу тутмын 1 нь сонгуулийн кампанит ажилд оролцож байжээ.



“Улс төр, хуулийн мэргэжлийн оюутнууд сонгуулийн сурталчилгаанд ажиллавал сурч байгаа мэргэжлийнхээ талаас их юм сурах, ажиглах, дадлага хийх боломжтой байдаг. Онолын талаас нь үзсэн зүйлүүдээ практик дээр судалж харьцуулаад, төгсөөд ажиллахад нь мэдэхгүй зүйлүүдээ анзаарсан, ажигласан байхад нэмэртэй санагдсан.”

Улс төр судлаач, эрэгтэй, 24 нас


“Оюутнууд сонгуулийн үеэр маш олноороо сонгуулийн сурталчилгааны ажилд ухуулагч хийдэг. Манай нэг найз шөнө яваад өрсөлдөгчийнх нь сурталчилгааг “муухай” болгож байсан. Янз бүрийн л ажил хийлгэдэг юм байна лээ. Ойр тойрныхоо хүмүүсийн баахан регистрийн дугаар цуглуулж өгөөд сурталчилгаанд ажилласан хөлсөө авсан гэсэн. Зарим нэг найзууд маань ажилласан мөнгөө дутуу авсан гэж байсан.”

Инженерийн мэргэжлийн оюутан, эрэгтэй, 20 нас

“Сонгуулийн үеэр тролл буюу сошиал дээр пост оруулдаг, нэр дэвшигчийнхээ талаарх мэдээг группууд руу шэйрлэдэг, эерэг комент бичдэг, эерэг эможи дардаг ажлуудыг аймгийнхаа хэсэг залуучуудтай нийлж хийсэн. Нэг хүн дор хаяж 5 ширхэг хуурамч хаяг нээгээд түүгээрээ энэ ажлуудыг хийж байсан. Одоо бодоход жоохон муухай юм хийчихсэн ч юм шиг санагдаж байна.”

Нийгмийн ухааны мэргэжлийн оюутан, эрэгтэй, 21 нас

Зураг 13. Ухуулагчаар ажилласан бол тухайн нам, нэр дэвшигчид саналаа өгсөн эсэх



Сонгуулийн сурталчилгаа, кампанит ажилд ухуулагчаар ажиллаж байсан залуучуудын 52 хувь нь буюу дийлэнх нь ажиллаж байсан тухайн нам, нэр дэвшигчийнхээ төлөө саналаа өгдөг байна. Харин 7 хувь нь энэ асуултад хариулахаас татгалзсан бол 41 хувь нь өөрийн бодлоор саналаа өгсөн гэж хариулжээ.




“2020 оны сонгуулийн үеэр сонгуулийн ажилд оролцсон. Нэр дэвшигчийнхээ мөрийн хөтөлбөр, хийх гэж байгаа ажлуудыг иргэдэд танилцуулаад, тайлбарлаад зөндөө ажиллалхаад багт нь ажилласан нэр дэвшигч ялаад гараад ирвэл гоё санагддаг юм билээ. Дараагийн сонгуульд нь бас ажиллана гэж бодож байгаа.”

Нягтлан бодох мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас

“Оюутнууд юм уу, орон нутагт байгаа залуучууд сонгуулийн сурталчилгаанд хөлс мөнгөтэйгээр ажиллая гэж бодож сонгуулийн ажил хийдэг байх. Яг над шиг их сургуулиа төгсөөд ажил төрөл хийдэг болсон залуучууд заавал мөнгө харж сонгуульд ажиллах биш, өөрийнхөө итгэл үнэмшлээрээ тухайн дэмжиж байгаа нэр дэвшигчээ үзэл бодлоороо дэмждэг санагддаг. Яг туслаад дэмжээд хэрвээ УИХ-ын гишүүн болчих юм бол улс орон зөв бодлого гаргаад иргэддээ хэрэгтэй зүйл хийвэл зүгээр гэж бодож зарим улс төрчдийг дэмжиж сонгуулийн сурталчилгаанд нь оролцсон. Сурталчилгааны материалыг нь тарааж, хүмүүст социал орчинд уриалахаас гадна албан ёсных нь дансанд хандив өгсөн.”

Барилгын инженер, эрэгтэй, 26 нас

Зураг 14. Өнөөгийн улс төрийн байдлыг үнэлсэн үнэлгээ



Залуучууд өнөөгийн улс төрийн байдлыг ерөнхийд нь замбараагүй байна хэмээн үнэлсэн. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 88 хувь нь “улс төр хэт замбараагүй”, “сонгууль дөхөөд улс төр бужигнасан байдалтай байна” гэж хариулжээ. Харин бусад хэмээх хариултыг өгсөн оролцогчдын хувьд мөн л улс төр эмх замбараагүй байгаа талаар шүүмжилсэн тайлбарууд бичсэн байв.


2.3 ЗАЛУУЧУУДЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ОРОЛЦОО, ХАНДЛАГА

Судалгааны энэ хэсэгт Z үеийн залуучуудын (17-26 нас) сонгуулийн оролцоо, хандлагыг тодорхойлохдоо тэдний сонгуулийн талаарх ойлголт, үзэл бодол, сонгуульд оролцож саналаа өгдөг эсэх зэргийг судаллаа.

*Мөн энэ хэсэгт судалгааны фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын хүрээнд залуучуудын илэрхийлсэн байр суурь, санал бодлыг **ШИГТГЭЭ** болгон орууллаа. Гэхдээ эдгээр **ШИГТГЭЭ** нь энэхүү асуулгын судалгааны үр дүнг батлах эсвэл няцаах зорилго агуулаагүй, судалгаанд оролцсон залуучуудын зарим байр суурь, санал бодол гэдгийг дахин дурдая.*

ЗАЛУУЧУУДЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ОРОЛЦОО, ХАНДЛАГА

Зураг 15. Сонгуульд оролцох нь чухал эсэх



Судалгаанд оролцсон залуучуудын 95 хувь нь сонгуульд оролцох нь “маш чухал”, “чухал” гэж хариулсан байна. Харин сонгуульд саналаа өгөх нь “нэг их чухал биш”, “чухал биш” гэж үзсэн залуучуудын хувь маш бага байна.




“ЕБС-ийн сурагч байхдаа би болон манай найзууд улс төрийг ерөөсөө сонирхдоггүй байсан. Их сургуульдаа ороод оюутны сайн дурын мэтгэлцээний клубт сонирхоод явсан. Тэнд зарим багш нар, лекторууд ирж нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүйн талаар сонирхолтой лекцүүд уншдаг байсан. Тэр клубээсээ сурсан, ойлгож авсан зүйл маань улс төр зөв, шударга байх ёстой, хүний эрх, эрх чөлөө гэх мэт асуудлууд ямар чухал байдаг вэ гэдгийг ойлгож авсан. Тэгээд түүнээс хойш фэйсбүүк дэх найзууддаа, танилууддаа улс төрд идэвхтэй байх, аливаад зөв оролцоотой иргэн байхыг уриалдаг болсон.”

Даатгалын салбарын ажилтан, эмэгтэй, 25 нас

“Залуучууд сонгуульд л саналаа өгч оролцсон нь дээр байх. Өөрсдөө сайн төлөвшөөгүй байж улс төр, улс орны бодлогын асуудалд оролцох нь сайн биш гэж би хувьдаа боддог.”

Багш мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас

Зураг 16. Сонгуулийн талаарх ойлголт



Судалгаанд оролцсон залуучуудын 77.7 хувь нь сонгуулийг “төрд биднийг төлөөлөх хүнийг сонгох арга” хэмээн үзжээ. Харин залуучуудын 24-25 хувь нь “ардчилсан төрийг бүрдүүлж буй явдал”, “иргэний эрхээ эдлэх боломж” зэрэг хариултууд өгсөн байна.



“Би орон нутагт, бүүр хөдөө амьдардаг л даа. Улс төрчид биднийг ойлгож, малчдын талаар дорвитой шийдвэрүүд гаргаж байгаа. Хөдөө яг мал маллаад амьдрах бидний үеийн залуучууд их ховордсон. Би хувьдаа сонгуульд саналаа өгөхдөө манай орон нутагт бидний төлөө ямар сайн зүйлс хийсэн хүн бэ гэдгийг харж өгдөг.”

Малчин, эрэгтэй, 26 нас

“Залуучууд маань улс төрд илүү оролцоотой байх тусмаа бидний амьдрал илүү сайн, сайхан байна гэдгийг сайн ойлгох хэрэгтэй. Ерөнхий боловсролын сургуулийн сурагч байхад, бүүр оюутан байхдаа ч эдгээр зүйлсийг төдийлөн сайн анзаардаггүй байсан. Төгсөөд ажлын байр дээр гараад улс төрийн асуудлууд бидний өдөр тутмын амьдралд ямар их нөлөөлдөг вэ гэдгийг маш сайн ойлгож ухаардаг юм билээ.”

Хувиараа бизнес эрхлэгч, эмэгтэй, 26 нас

Хүснэгт 5. Сонгуулийн талаарх мэдээлэл авдаг байдал

	Мэдээлэл маш сайн	Мэдээлэл сайн авдаг	Мэдээлэл муу авдаг	Огт мэдээлэл	Хэлж мэдэхгүй
Сонгуулийн санал авах өдөр	44%	10%	37%	5%	4%
Сонгуулийн тойргийн хуваарилалттай холбоотой	24%	36%	24%	11%	5%
Сонгогчийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл	20%	36%	27%	11%	6%
Саналаа хаана очиж өгөх буюу санал хураах байрны байршлын талаарх мэдээлэл	34%	39%	16%	6%	5%
Санал өгөх өдөр миний зүгээс ямар бэлтгэлтэй очих	37%	37%	15%	6%	5%
Нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл	28%	42%	19%	6%	5%
Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг хаанаас уншиж, мэдэх	25%	40%	22%	8%	5%
Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг хэрхэн унших, дүгнэх, харьцуулах	21%	39%	25%	9%	6%
Санал өгөх үйл явц хэрхэн явагддаг тухай	28%	38%	21%	8%	5%
Сонгуулийн булхай, хууль бус зүйлс гэх мэт анхаарах ёстой асуудлуудын талаар	21%	33%	28%	11%	7%
Саналаа өөрөө бие дааж гаргахад юуг анхаарах тухай	31%	35%	20%	9%	5%
Урьд өмнө сонгогдож байсан нэр дэвшигчдийн сонгуулийн өмнөх амлалт нь хэр зэрэг биелсэн тухай	20%	33%	27%	13%	7%
Сонгуулийн сурталчилгаа, түүний явц	20%	37%	26%	11%	6%
Бусад	14%	25%	25%	14%	22%

Сонгуулийн талаарх мэдээллийг ангилж, сонгогчдод хүрч буй хүртээмжийн талаар асуухад судалгаанд оролцогчдын 62 хувь нь “мэдээлэл маш сайн авдаг”, “мэдээлэл сайн авдаг” гэж хариулжээ.




“УИХ болон Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл надад маш ойлгомжгүй санагддаг. Олон тойрог, олон хүн нэр дэвшиж өрсөлддөг болохоор тэгдэг байх. Харин Ерөнхийлөгчийн сонгуульд улсын хэмжээнд 2-3 нэр дэвшигч өрсөлддөг учраас мэдээлэл авахад амар, ойлгомжтой байдаг. Гэхдээ л би мэргэжлийн ангийн оюутан хэрнээ тэдгээр нэр дэвшигчдийн талаарх хэрэгтэй мэдээллүүдийг хаанаас нэгдсэн байдлаар аваад, сонголт хийхдээ ашиглах вэ гэдгээ сайн мэдэж чадалгүй л сонгуульдаа оролцсон.”

Эрх зүйн мэргэжлийн оюутан, эрэгтэй, 22 нас

“Би сонгуулийн хуулиар юуг зохицуулдаг, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн тойрог гэж юу байдаг, нэр дэвшигчдэд ямар шаардлага тавьдаг зэргийг мэддэггүй учраас сонгуулийг төдийлөн тоодоггүй, саналаа өгдөггүй. Гэхдээ зөвхөн сонгуульд оролцох нь л улс төрийн оролцоо гэж ойлгож байснаас сая та бүхний хэлсэн шиг өөр олон улс төрийн оролцоо байдаг гэдгийг мэддэггүй, төсөөлж байгаагүй юм байна.”

Урлагийн салбарын оюутан, эрэгтэй, 19 нас

Зураг 17. Сонгуульд оролцож байсан туршлага



Судалгаанд оролцсон залуучуудын 16 хувь нь сонгуулийн насанд хүрээгүй учир санал өгч байгаагүй, 77 хувь нь сонгуульд оролцож саналаа өгч байсан бол 7 хувь нь сонгуульд оролцох нас хүрсэн боловч саналаа өгч байгаагүй гэж хариулжээ.

Зураг 18. Сонгуульд оролцох нас хүрсэн ч, саналаа өгч байгаагүй шалтгаан



Сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгааныг тодруулахад, “сонгуульд оролцох зав гараагүй”, “итгэл хүлээлгэх нам, улс төрч байгаагүй”, “улс төрчид, намууд шударга биш”, “миний саналаас үл хамааран сонгууль болдогоороо болно”, “саналаа өгөх нь төвөгтэй байсан”, “сонгуульд санал өгөх талаар ойлголтогүй байсан” зэрэг хариултууд өгсөн юм. Харин сонгуульд оролцоогүй “бусад” шалтгаанд нийслэлд, орон нутагт эсвэл гадаадад байсан буюу сонгуульд саналаа өгөх харъяаллын бус газарт ажиллаж, сурч, амьдарч байснаас хамаарч сонгуульд саналаа өгч чадаагүй гэсэн хариулт дийлэнх хувийг эзэлж байлаа.



“Ихэнх залуучууд улс төрийн оролцоо гэдгийг сонгуульд оролцож саналаа өгөх л гэж ойлгодог байхаа. Миний бодлоор иргэний нийгмийн байгууллагад элсэх, сайн дурын клубуудад ажиллах, социалд лайк дарах, эсвэл шэйрлэх, өөрийн саналаа бичих ч гэсэн оролцооны хэлбэр гэж боддог. Жишээ нь, “Паркаа аварья” зэрэг цахим хөдөлгөөнийг дэмжиж байгаагаа илэрхийлж байгаа нь оролцоо гэж бодож байна.”

Багш мэргэжлийн оюутан, эрэгтэй, 20 нас

“Залуучууд бүгдээрээ улс төрд оролцоно гэж байхгүй байхаа. Жишээ нь, амьдралын боломжтой, ядаж ухаалаг утастай залуу социалд ороод улс төрийн оролцоогоо илэрхийлж байхад гэр хороололд эсвэл бүүр хөдөө байгаа залуучууд социалаар улс төрд оролцож чадахгүй. Ядаж л бүрэн гүйцэт улс төрийн талаарх мэдээлэл авч чадахгүй биз дээ. Амьдралын боломж тааруу хүмүүст халамж, хүнсний талон өгөх, бүүр нөгөө бэлэг тараагаад өөртөө санал өгүүлдэг. Ийм нөхцөлд байгаа залуучууд улс төрийг жинхэнэ утгаар нь ойлгож, харьцуулж оролцох биш, саналаа тэр хүнд өг гэсний дагуу л саналаа өгөх байх. Тэгэхээр ийм залуучуудад улс төрд хэрхэн оролцох болон улс төрийн мэдлэг, боловсрол олгоход анхаарах хэрэгтэй санагдаж байна.”

Программист, эмэгтэй, 25 нас

Зураг 19. 2020 онд болж өнгөрсөн сонгуулиуд шударга, зөв болсон эсэх



Судалгаанд оролцогчдын 12 хувь нь 2020 оны УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль шударга болсон гэдэгт итгэлтэй байна. Бусад хариултуудын хувьд УИХ-ын сонгуулийн талаар дүгнэсэн хариултууд ИТХ-ын сонгуулийг дүгнэсэн хариултын хувиас бага байлаа. Эндээс залуучууд УИХ-ын сонгуулийн талаар Орон нутгийн сонгуулиас илүү мэддэг, анзаардаг байна.



“Сонгуульд анх удаа саналаа өгөх гэж байгаа 17-18 насны залуучууд яг сонгууль сонирхдоггүй, тэдний хувьд ямар мэргэжил сонгох, ямар сургуульд элсэх вэ гэдэг нь чухал байдаг. Магадгүй анхнаасаа улс төрийн мэдлэг сайн олгоогүйтэй ч холбоотой байж болох юм. Оюутан болоод мэргэжлээ, сургуулиа сонгочихсон учраас арай учиртай болоод сонгуульд саналаа өгөх нь чухал юм байна гэж ойлгоод саналаа өгдөг болдог. Харин их сургуулиа төгсөөд ажил, амьдрал дээр гарахаараа улс төрийг сонирхох байдал өөрчлөгдөх байхаа.”

Олон улсын харилцааны мэргэжлийн оюутан, эрэгтэй, 20 нас


“Би лав сонгуулийн дүн цаанаасаа тодорхой байдаг, миний санал сонгуулийн үр дүнд нөлөөлөхгүй гэж боддог. Манай ангийнхан энэ талаар боддог эсэхийг сайн мэдэхгүй юм байна.”

Биеийн тамирын мэргэжлийн оюутан, эрэгтэй, 22 нас

“Юм болгоныг залуучуудын буруу, тэд л оролцохгүй байна, тэдний идэвхгүй байдлаас боллоо гэдэг нь над руу шууд хандаж хэлээд байгаа юм шиг санагддаг. Улс төрийг улам сонирхмооргүй санагддаг. Тийм болохоор сонгуульд саналаа өгдөггүй.”

Эрчим хүчний мэргэжилтэн, эмэгтэй, 25 нас

Зураг 20. Сонгуульд санал өгөхөд чухалчилдаг хүчин зүйлс



Судалгаанд оролцсон залуучууд сонгуульд саналаа өгөхдөө ихэвчлэн нэр дэвшигчийг, мөрийн хөтөлбөр, сонгуулийн өмнөх улс төрийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн сонголтоо хийдэг гэж хариулжээ. Эдгээр хариултууд хамгийн их чухалчилдаг 2-3 сонголтод өндөр хувьтайгаар давхардсан байна. Харин гэр бүл, ойр дотны хүмүүсийн санал болон улс төрийн нам, эвслийг харьцангуй бага харгалздаг аж.



“Анх удаа саналаа өгөхдөө сонгуулийн талаар ямар ч ойлголтгүй байсан учраас эцэг эхийнхээ саналыг сонсож, тэдний хэлснээр саналаа өгч байсан. Дараагийн сонгуульд нь социал медиа дээрх мэдээллүүдийг харж байгаад өөрөө сонголт хийсэн. Өөрөө сонголт хийхэд их сонирхолтой юм билээ. Гэхдээ сонголтоо зөв хийхэд яг юунд, яаж анхаарах ёстойг мэдмээр байна.”

Олон улсын харилцааны мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас


“ЕБС төгсөөд хоёр удаагийн сонгуульд оролцож саналаа өгсөн. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд бас саналаа өгнө. Эмээ маань хорооныхоо “...” намд ажилладаг байсан. Манай эмээ 8 хүүхэдтэй, хүргэн, бэрүүд, хүүхдүүд гээд бараг бүгд тэр намд элссэн. Бас бүгдээрээ эмээгийн хэлснээр тэр намыг дэмжиж саналаа өгдөг.”

Нийгмийн ухааны мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас

“Манай ангийнхан, найзууд сонгуулийн сурталчилгаанд ухуулагчаар ажилласан. Гэхдээ би ажиллаагүй л дээ. Сурталчилгаанд ажиллаж байсан ч манай нэр дэвшигчийг битгий сонгож саналаа өгөөрэй, харин нөгөө нэр дэвшигчийг нь сонгоорой гээд найзууд маань надад хэлээд нөлөөлж байсан. Би бодож байгаад найзуудынхаа хэлсэн хүнд саналаа өгч байсан.”

Хуулийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас

Зураг 21. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг эсэх



Сонгуулийн мөрийн хөтөлбөртэй холбоотой асуултад нэгэн онцлох үр дүн байсан нь залуучуудын 77 хувь нь сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй эртнээс танилцах хүсэлтэй, улмаар тойм багцалсан мэдээллийг уншиж танилцаад, сонголтоо хийдэг гэсэн хариултыг өгчээ.




“Өмнөх жил болсон УИХ-ын, Орон нутгийн сонгуулиудад манай зарим найзууд саналаа өгөөгүй байсан. “Яагаад саналаа өгөөгүй юм бэ” гээд асуухад “улс төр сонирхдоггүй” гэж хариулсан. Бас зарим саналаа өгсөн найзууд маань мөрийн хөтөлбөрийг нь харьцуулж уншаагүй, улс төрийн талаарх ойлголтгүй болохоороо нэр дэвшигчийн “царай”-г нь харж байгаад саналаа өгсөн гэж хэлж байсан.”

Нийгмийн ухааны мэргэжлийн оюутан, эрэгтэй, 21 нас

“Улс төрийн оролцоо гээд ярихаар сонгуульд саналаа өгөх нь хамгийн наад захын оролцооны хэлбэр гэж би ойлгодог. Сонгуульд оролцоогүй хүн бол уг чанараараа “боол” гэж Аристотель хэлсэн байдаг. Төрийг удирдах буюу өөрийгөө төлөөлөх хүнийг сонгоход оролцохгүй байна гэдэг нь үүнийг хүлээн зөвшөөрч байгаатай л адилхан гэж боддог. Залуучуудын улс төрийн оролцоо гэдгийг манай үеийнхэн тийм сайн ойлгохгүй байгаа. Ядаж мөрийн хөтөлбөр уншиж саналаа өгөх ёстойг сайн ойлгох хэрэгтэй. Тиймээс бидний үеийнхэнд зориулсан мэдээллүүдийг сайн өгч анхаарвал бас болох л байх.”

Эдийн засгийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 21 нас

Зураг 22. Монгол Улсыг удирдах хүний шинж



Монгол Улсыг удирдах ёстой хүмүүсийн хувьд нэн тэргүүнд шаардагдах шинжүүд нь “өндөр боловсролтой” (65 хувь), “шударга” (61 хувь) “ёс суртахуунтай” (56 хувь), “хариуцлага хүлээх чадвартай” (56 хувь), “хэлсэн, амалсандаа хүрдэг хүн” (51 хувь) байх хэмээн залуучууд үзэж байна.




“Улс төр эсвэл улс төрийн оролцоо гэхээр, надад одоо байгаа манай улс төрчид шууд төсөөлөгдөөд байдаг юм. Гэрийнхэн маань бараг өдөр бүр л улс төрчид болон намуудын болохгүй, бүтэхгүй байгаа, буруу шийдвэр гаргаад байгааг ярьж шүүмжилдэг болохоор тэгж л төсөөлдөг. Тэгэхээр улс төрийг сонирхох, анзаарах сонирхол төрдөггүй.”

МСҮТ-ийн оюутан, эрэгтэй, 18 нас

“Улс төрчид болон нэр дэвшигчид сонгогчдын саналыг худалдан авах, худал амлалт өгөх нь улам л нэмэгдэж байна. Гэтэл үүнийг манай сонгогчид байх ёстой үзэгдэл юм шиг хүлээж авдаг, тоодоггүй, харин ч мөнгө, бэлэг өгсөн улс төрчдийг дахиад сонгоод байдаг буруу хандлагатай болсон. Биднийг төлөөлөх улс төрч ийм аргаар сонгуульд ялалт байгуулвал, эргээд сонгогч бидний төлөө ажиллана гэж байхгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Энэ мэт наад захын улс төрийн асуудлыг улс орны ирээдүй болсон залуучууд бид нар мэддэг, анзаардаг, эсэргүүцдэг байх ёстой”

Улс төр судлаач, эмэгтэй, 23 нас

Зураг 23. Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх эсэх (2021.06.09)



Судалгаанд оролцсон залуучуудын 80.2 хувь нь 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгнө гэж хариулжээ. Энэхүү судалгааны зорилтот түүвэр бүрдсэн тул судалгааг 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хариултуудыг нэгтгэсэн юм.

2021 оны 6 дугаар сарын 9-ний өдөр болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд 18-19 насны залуучуудын 56.45 хувь, 20-24 насны залуучуудын 43.72 хувь, 25-29 насны залуучуудын 46.32 хувь нь саналаа өгчээ. Уг судалгаанд “саналаа өгнө” гэж 80.2 хувь нь хариулж байсан бол бодит байдал дээр дунджаар 48 хувь нь сонгуульд оролцож саналаа өгчээ.



“Уг нь сонгууль, улс төр ямар чухал вэ гэдгийг мэднэ л дээ. Гэхдээ би сонгуулийн насанд хүрэхэд хотод оюутан болчихсон хичээлдээ сууж байсан. Тэр сонгууль орон нутгийн төлөөлөгчдийг сонгох сонгууль байсан. 10 сард хичээлийн дундуур нэгхэн өдөр амрахад би бүүр Завхан руу очиж саналаа өгчихөөд буцаж ирээд маргаашийнхаа хичээлдээ сууж чадахгүй шүү дээ. Манай ангийнхнаас Улаанбаатартай ойр аймагт гэр нь байдаг хүүхдүүд зарим нь очиж саналаа өгсөн. Очихгүй гэж шийдсэн байсан хүүхдүүдийг хүмүүс утсаар яриад унааных нь зардлыг даагаад авч явсан, манай зарим найзуудыг бүүр нэгдсэн байдлаар унаа гаргаж авч яваад очиж саналыг нь өгүүлж байсан. Хичээлийн дундуур зардлаа даалгаад гэрийнхэнтэйгээ уулзчихаад ирлээ гээд хүүхдүүд баярлаад л байсан.”

Инженерийн мэргэжлийн оюутан, эрэгтэй, 19 нас

“Миний хувьд сонгуульд нэр дэвшигчид болон намуудын мөрийн хөтөлбөрийг уншиж танилцах ёстой, тэгж байж сонголтоо хийгээрэй гэдэг фэйсбүүк дээрх постыг харж байсан. Гэхдээ сонгуулийн цаг үеэр хичээлийнхээ шалгалтыг өгөх, дүнгээ гаргуулах гэх мэтээр завгүй цаг үе таарч байсан учраас сонгуульд саналаа өгөхгүй, өөр зүйлдээ цаг зарцуулья гэж бодсон. Угаасаа мөрийн хөтөлбөрийг уншъя ч гэж бас бодогдоогүй. Энэ талаарх ойлголт байхгүй учраас мөрийн хөтөлбөрийг сонирхдоггүй.”

Инженерийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 20 нас

2.4 УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВДАГ ЭХ СУРВАЛЖ, СУВАГ

Судалгааны энэ хэсэгт Z үеийн залуучуудын (17-26 нас) улс төрийн талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, улс төрийн мэдээллийн хүртээмж, залуучуудад улс төрийн мэдээлэл хүргэх боломжтой сувгууд зэргийг судаллаа.

*Мөн энэ хэсэгт судалгааны фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын хүрээнд залуучуудын илэрхийлсэн байр суурь, санал бодлыг **ШИГТГЭЭ** болгон орууллаа. Гэхдээ эдгээр **ШИГТГЭЭ** нь энэхүү асуулгын судалгааны үр дүнг батлах эсвэл няцаах зорилго агуулаагүй, судалгаанд оролцсон залуучуудын зарим байр суурь, санал бодол гэдгийг дахин дурдая.*

УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВДАГ ЭХ СУРВАЛЖ, СУВАГ

Хүснэгт 6. Улс төрийн талаарх мэдээллийн эх сурвалж

	Өдөр тутам	7 хоногт 2-3 удаа	7 хоног тутам	14 хоног тутам	Сар тутам	Огт авдаггүй
Телевиз	13%	13%	10%	7%	8%	3%
Сонин, сэтгүүл	4%	8%	7%	9%	12%	9%
Мэдээний сайтууд	15%	14%	11%	8%	6%	2%
Радио, Фм	4%	5%	6%	8%	7%	12%
Фэйсбүүк	25%	11%	7%	5%	4%	2%
Твиттер	7%	6%	5%	5%	6%	11%
Инстаграм	6%	6%	7%	8%	6%	11%
Youtube	5%	4%	7%	7%	9%	12%
Tik Tok	2%	2%	3%	5%	7%	15%
Гэр бүлийн гишүүдээсээ	8%	12%	12%	12%	10%	4%
Найз нөхөд, үеийнхнээсээ	5%	9%	14%	14%	11%	5%
Багшийн заасан хичээлээс	4%	7%	9%	10%	10%	9%
Бусад	1%	2%	2%	3%	4%	5%


Судалгаанд оролцсон залуучуудын 25 хувь нь өдөр тутмын улс төрийн мэдээг фэйсбүүкээс, үүнээс харьцангуй урт хугацаанд улс төрийн мэдээллийг найз, нөхөд, үеийнхэн, мэдээний сайтуудаас авдаг бол, Tik tok сүлжээнээс улс төрийн мэдээлэл огт авдаггүй гэсэн хариултыг өгчээ.



“Манай ЕБС болон, их, дээд сургуулиудын алинд ч улс төрийн боловсрол олгох хичээл хангалттай хэмжээнд ордоггүй. Магадгүй улс төр, хууль болон нийгмийн ухааны зарим чиглэлийн мэргэжлээр суралцаж байгаа оюутан, судлаачид л нарийн судалдаг байх. Дунд сургуульд үздэг “Нийгмийн тухай мэдлэг” хичээлийн багахан цаг нь л улс төртэй холбоотой мэдлэг байдаг. Гэтэл тэр хичээлийг хүүхдүүдэд үр дүнтэй сайн зааж, ойлгуулж чадахгүй байгаа. Энэ нь залуучууд анхны сонгуульдаа идэвхгүй оролцох, цаашлаад улс төрийг ойлгохдоо тааруу иргэн болгоход нөлөөлдөг. Улс төрийн боловсролыг аль болох багаас нь олгодог, анхаардаг болмоор байна.”

Судлаач, эмэгтэй, 24 нас

Зураг 24. Улс төрийн мэдээллийн хүртээмж



Судалгаанд оролцсон залуучуудын 38 хувь нь улс төрийн мэдээлэл “хүртээмжтэй”, 40 хувь нь “хүртээмжгүй” гэж хариулсан бол энэ талаар “мэдэхгүй” гэж 22 хувь нь хариулсан байна.

Хүснэгт 7. Улс төрийн асуудлаар санал солилцдог байдал

	Маш их	Их	Дунд	Бага	Огт үгүй
Өвөө эмээ	10%	11%	19%	15%	45%
Эцэг эх	15%	22%	32%	17%	14%
Ах, эгч нар	9%	16%	30%	21%	2%
Найз нөхөд	14%	21%	29%	20%	4%
Ангийнхан	10%	17%	25%	18%	16%
Багш нар	7%	13%	23%	19%	30%
Хамт ажилладаг хүмүүс	8%	14%	25%	16%	37%
Бусад	7%	9%	21%	13%	50%

Улс төрийн асуудлаар ойр дотныхны нөлөөг тодруулах зорилгоор асуусан асуултад судалгаанд оролцсон залуучууд ихэвчлэн эцэг, эх, ах, эгч, найз нөхөдтэйгээ тодорхой хэмжээний санал солилцдог байна. Харин өвөө, эмээ, ангийнхан, багш нар, хамт ажилладаг хүмүүстэйгээ хамгийн бага санал солилцдог байна.




“Би улс төр судлалын ангийн оюутан учраас улс төрийн мэдлэг залуучуудад, миний үеийнхэнд ямар чухал вэ гэдгийг мэднэ. Тэгээд найзууддаа улс төрийн талаар тайлбарлаад ярих гэхээр “миний найз боль оо, улс төр яривал чамайг сонсохгүй ээ, хэт их улс төржөөд байна” гэдэг. Би нэг хөгшин хүн тэд нарт улс төрийн талаар юм ярьж өгөх гэж байгаа юм шиг болдог. Харин найзууддаа биш гэр бүл, эмээ, өвөөдөө улс төрийг тайлбарлаад ярихаар миний ярьж байгааг ойлгоод, дэмждэг. Ер нь залуучууд улс төр сонирхдоггүй санагддаг.”

Улс төр судлалын мэргэжлийн оюутан, эмэгтэй, 21 нас

“Эцэг эх, өвөө эмээ нар тухайн нэр дэвшиж байгаа хүнийг нь харахгүйгээр аль намаас нэр дэвшиж байгаа гээд намыг нь харж сонголтоо хийдэг. Намайг ч гэсэн өөрсдийнхөө дэмждэг намыг заавал сонгоорой гэж байсан. Эмээ, өвөөтэйгөө ойр өссөн залуучуудад бол тэд шууд л нөлөөлдөг дөө.”

Физикийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 22 нас

Зураг 25. Улс төрийн талаарх зарим сэдвүүдийг сонирхдог эсэх




Судалгаанд оролцсон залуучуудаас улс төрийн зарим суурь ойлголтын талаарх сэдвүүдийг сонирхдог эсэхийг асуусан асуултад “ардчилал”, сонгуулийн тухай” мэдээлэл бусдаас илүү буюу “маш их сонирхолтой, сонирхолтой” санагддаг гэж хариулсан байна. Харин улс төрийн нам болон хувь улс төрчийн тухай мэдээллийг хамгийн бага сонирхдог байна.



“Залуучууд ядаж “Үндсэн хууль”-ийн талаар мэдлэгтэй, ойлголттой болох хэрэгтэй. Өөрийнхөө эрх үүргийг ойлгодог, Үндсэн хуулийнхаа зарчмуудыг мэддэг бол төр засаг ямар байх ёстой, бүүр цаашлаад тэдэнд анхан шатны шаардлага, хяналт тавих зэргээр улс төрийн оролцоотой болж болох юм.”

Хуулийн мэргэжлийн оюутан, эрэгтэй, 21 нас

Зураг 26. Цахим орчинд гарч ирдэг улс төрийн талаарх мэдээлэлд хандах байдал



Судалгаанд оролцсон залуучуудын 53 хувь нь цахим орчинд улс төрийн холбогдолтой мэдээлэл, пост гарч ирэхэд уншилгүй алгасдаг, 10 хувь нь ямар эх сурвалж дээр тухайн мэдээлэл байгааг харгалзан уншдаг бол 28 хувь нь тогтмол орж уншдаг байна.




“Фэйсбүүк дээр бараг бүх телевиз, сайтууд пэйжтэй болчихсон учраас заавал телевиз асааж нийгэм, улс төрийн мэдээ үзнэ гэхээ больсон. Хэзээ бол хэзээ, хаанаас ч эдгээр мэдээллийг үзэж, уншиж болно. Гэхдээ миний фэйсбүүкт заримдаа улс төрийн агуулгатай мэдээ гараад ирвэл, гарчигийг нь харж байгаад сонирхолтой санагдвал орж уншдаг. Бас хааяа тэр улс төр, сонгуулийн талаарх мэдээлэлд лайк дарах, эсвэл онцгүй таагүй санагдсан мэдээнд уурласан, онцгүй байна гэсэн эможи дардаг. Тэгэхээр энэ үйлдлүүд маань миний хувьд улс төрийн орчинд оролцож байгаа хэлбэр гэж бодож байна.”

Нийгмийн ухааны мэргэжлийн оюутан, эмэгтэй, 21 нас

“Цахим орчинд өөртөө ирсэн мэдээллийг шалгах, найзуудтайгаа холбогдох, мэдээлэл үзэх гэхээр ялангуяа сонгууль дөхөөд ирэхээр улс төр, сонгууль, улс төрчидтэй холбоотой маш их мэдээлэл гарч ирээд бас хэцүү байдаг. Маш их улс төрийн мэдээлэл гарч ирээд байхаар харин ч эсрэгээрээ сонирхмооргүй санагддаг.”


Урлагийн мэргэжлийн оюутан, эмэгтэй, 19 нас

Зураг 27. Улс төрийн албан тушаалтнуудыг таньдаг эсэх



Судалгаанд оролцсон залуучуудын 93 хувь нь Ерөнхийлөгчийг, 86 хувь нь Ерөнхий сайдыг, 77 хувь нь УИХ-ын даргыг, 68 хувь нь өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнийг, 49 хувь нь өөрийн амьдарч буй аймаг/дүүргийн засаг даргаа, хамгийн бага буюу 37 хувь нь өөрийн тойргоос сонгогдсон ИТХ-ын гишүүнийг танина гэж хариулжээ.

Зураг 28. Улс төрийн байгууллагуудад залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байгаа эсэх




Дээрх улс төрийн байгууллагууд буюу УИХ, Засгийн газар, ИТХ, Төрийн албанд залуучуудын төлөөлөл хангагдаж чадаж байгаа эсэхэд “чадахгүй байна”, “мэдэхгүй” гэж судалгаанд оролцогчдын 76-87 хувь нь хариулжээ.

Хүснэгт 8. Сонгуулийн зарим ойлголтуудын талаарх мэдлэг

	Маш сайн мэднэ	Ер нь мэднэ	Бага зэрэг мэднэ	Нэг их мэдэхгүй	Огт мэдэхгүй
Сонгуульд “Цагаан сонголт” хийх гэсэн ойлголтын талаар	29.1%	23.9%	13.6%	11.5%	21.9%
Сонгогч сонгуульд саналаа өгөхгүй бол гардаг сөрөг асуудлуудын талаар	31.6%	30.3%	18.0%	10.7%	9.4%
Сонгогчдын саналыг худалдаж авах, түүний сөрөг талуудын талаар	37.8%	29.3%	16.1%	7.7%	9.1%

Сонгогчдын хувьд зайлшгүй мэдэх шаардлагатай ойлголтууд болох “цагаан сонголт”, “сонгуульд оролцож саналаа өгөх”, “санал худалдан авах” зэрэг ерөнхий ойлголтуудын талаар асуусан асуултад судалгаанд оролцсон залуу сонгогчдын 65 хувиас илүү хувь нь их, бага хэмжээнд мэднэ гэж хариулжээ.

Зураг 29. Цахим орчин дахь хаяг, хамгийн түгээмэл хэрэглэдэг суваг



Судалгаанд оролцсон залуучуудын 99 хувь нь фэйсбүүк хаягтай. Тодруулбал, 16 хувь нь зөвхөн Фэйсбүүк, 24 хувь нь Фэйсбүүк ба Инстаграм, 19 хувь нь Фэйсбүүк, Инстаграм ба Ютүб гэсэн хаягуудтай байна. Энэ насны залуучууд фэйсбүүкт хамгийн их цаг зарцуулдаг. Судалгаанд оролцогчдын 20-21 хувь нь Тик-ток болон Твиттерт хаягтай хэдий ч эдгээр сувгуудад хамгийн бага цаг зарцуулдаг байна.

Хүснэгт 9. Зарим зүйлсэд цаг зарцуулах байдал

	Маш их цаг	Их цаг	Дунд зэрэг	Бага цаг	Огт цаг зарцуулдаггүй
Хичээл, даалгаврын талаарх мэдээллүүд	38%	31%	19%	6%	6%
Улс оронд болсон үйл явдлын мэдээ унших	10%	20%	40%	24%	7%
Имэйл шалгах	12%	19%	33%	29%	7%
Өөрийн цахим хаягуудад ирсэн мэдээллүүдээ шалгах	19%	29%	32%	17%	3%
Кино үзэх	11%	23%	35%	23%	8%
Бичлэг үзэх	13%	30%	37%	16%	4%
Дуу хөгжим	22%	29%	29%	16%	4%
Сошиал хуудсуудаар хэсэх	13%	25%	36%	19%	7%
Найз нөхөдтэйгөө уулзах /чатлах	18%	28%	33%	18%	4%
Тоглоом тоглох	8%	13%	24%	23%	32%
Бусад	7%	8%	24%	14%	46%

Залуучуудын хийдэг ерөнхий үйлдлүүдэд зарцуулдаг цагийн хуваарилалтаас харахад хичээл, даалгавраа хийх, мэдээлэл хайх зэрэгт маш их цаг зарцуулдаг гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь хариулсан бол, бусад үйл ажиллагаанд дунд зэрэг хугацаа зарцуулдаг байна.



“Сүүлийн үед залуучууд саналаа хэлэх, бичих нээлттэй болсон. Маш олон мэдээллийн сувгууд нээлттэй байна. Өөрсдөө юутүүб суваг нээгээд, блог хөтлөөд, пэйж, групп нээгээд санаа бодлоо, шинжлэх ухааны, эсвэл бүүр сонирхлынхоо дагуу ажиллах ч боломжтой болчихсон байгаа. Гэхдээ эдгээрийг хийхэд, ажиллуулахад яг бүрэн, цогц байдлаар байх ёстой, тэгж байж эдгээрийг хийж болох юм байна гээд боддог байхаа. Би бас тэдний нэг. Твиттерт залуучуудын оролцоо бага, харин бусад платформууд дээр нь чөлөөтэй гэж бодож байна. Гэхдээ залуучууд бидний оролцоо байсан ч залуучуудын санал төдийлөн олон нийтэд юм уу зохих газраа хүрдэг болов уу.”

Эмч, эмэгтэй, 26 нас

З



ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ


Судалгааны энэ хэсэгт Z үеийн залуучуудын (17-26 нас) улс төрийн оролцоо, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг энгийн статистик арга зүй ашиглан харьцуулав. Тодруулбал, судлаачдын зүгээс хамаарлыг шалгаж буй хувьсагчид дийлэнх нь чанарын шинжтэй байсан тул статистик харьцуулалт хийн судалсан болно.

3.1 УЛС ТӨРИЙН СТАТУСААС ХАМААРСАН ХАМААРАЛ

“Улс төрийн статус”-тай гэсэн ойлголтын хүрээнд аль нэг улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын гишүүн залуучуудыг хамруулан тооцов.

Судалгаанд оролцсон залуучуудын 13.2 хувь нь улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын гишүүн байв. Судалгааны энэ хэсэгт 17-26 насны Z үеийн улс төрийн статустай болон статусгүй залуучуудын улс төрийн оролцоо, сонгуульд саналаа өгөх ач холбогдол, мэдээллийн хүртээмжийн ялгаа байгаа эсэх зэрэг хамаарлыг шинжлэв.

Зураг 30. Улс төрийн статус, улс төр сонирхох байдлын хамаарал




Өдөр тутмын улс төрийн мэдээ болон Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, яам, агентлагтай холбоотой мэдээг сонирхож буй түвшингээр нь хамаарлыг харвал, улс төрийн статустай залуучууд улс төрийн статусгүй залуучуудаас илүү улс төрийг сонирхдог байна. Тухайлбал, нийт судалгаанд оролцсон улс төрийн статусгүй залуучуудын 11 хувь нь улс төрийн мэдээллийг “маш их сонирхдог” бол улс төрийн статустай залуучуудын хувьд тус төвшин даруй 5 нэгж хувиар өндөр байв.

Хүснэгт 10. Улс төрийн статустай залуучуудын улс төрийн сонирхол, дэлгэрэнгүй

	Маш их сонирхдог	Ер нь сонирхдог	Хааяа сонирхдог	Нэг их сонирхдоггүй	Огт сонирхдоггүй
Өдөр тутмын улс төрийн үйл явдал	20%	30%	30%	17%	3%
Ерөнхийлөгчийн гаргаж буй зарлиг, шийдвэр	13%	36%	36%	13%	1%
УИХ-аас баталж буй хууль, тогтоомжууд	17%	33%	36%	13%	1%
Засгийн газрын гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа	22%	35%	34%	8%	1%
Яам, агентлагаас гарч буй шийдвэр, үйл ажиллагаа	12%	29%	38%	18%	3%
Нийслэл, аймгийн засаг захиргаанаас гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа	13%	24%	35%	22%	6%
Дүүрэг, сумын засаг захиргаанаас гаргаж буй шийдвэр, үйл ажиллагаа	13%	23%	32%	24%	8%
Шүүхийн шийдвэрүүдийг	8%	24%	35%	24%	10%
Сонгуулийн үр дүнг	38%	26%	24%	10%	1%
Улс төрийн статустай	17%	29%	33%	17%	4%


Улс төрийн статустай залуучууд улс төрийн бүх төрлийн мэдээллийг “хааяа сонирхдог”, “ер нь сонирхдог”, “маш их сонирхдог” гэсэн хариултыг өгчээ. Эндээс тэд нийт залуучуудын дундаж хандлагаас илүү улс төрийг сонирхдог нь харагдаж байна. Мөн нөгөө талдаа улс төрийн статусгүй байх тусам залуучуудын улс төрийн сонирхол сул байна.

Зураг 31. Улс төр сонирхох түвшин, улс төрийн статусаар




Улс төрийн мэдээллийг сонирхох түвшин нэмэгдэхийн хэрээр улс төрийн статустай болон улс төрийн статусгүй залуучуудын сонирхлын зөрүү нэмэгджээ. Тодруулбал, улс төрийн статустай 100 залуугийн 4 нь улс төрийн мэдээллийг “огт сонирхдоггүй” бол улс төрийн статусгүй залуучуудын 12 нь “огт сонирхдоггүй” байна.

Зураг 32. Улс төрийн оролцоо, улс төрийн статусаар




Улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын гишүүн залуучуудын 85-90 хувь нь улс төрд “зарим үед оролцдог”, “байнга оролцдог” гэж өөрийгөө дүгнэсэн бол ямар нэгэн улс төрийн статусгүй залуучуудын хувьд тус оролцоо 67 хувь болж буурч байна.

Зураг 33. Улс төрийн оролцоо бүрийн дундаж, улс төрийн статусаар




Энд улс төрийн оролцоог ангилж, “заримдаа оролцдог”, “байнга оролцдог” эсэхээр дундаж оролцоог тооцвол улс төрийн статустай болон улс төрийн статусгүй залуучуудын хооронд 26 хувийн зөрүү үүсэж байна. Тухайлбал, улс төрийн статустай залуучуудын 94 хувь нь сонгуульд саналаа өгсөн/өгдөг бол улс төрийн статусгүй залуучуудын 77 хувь нь сонгуульд оролцож саналаа өгдөг байна.

Зураг 34. Улс төрийн оролцоо, улс төрийн статусаар



Улс төрийн оролцоо болон улс төрийн статусын дундажийг тооцон харьцуулахад ямар нэгэн улс төрийн статустай залуучуудын диаграм “байнга оролцдог” болон “заримдаа оролцдог” хариулт руу хазайсан байгаа бол улс төрийн статусгүй залуучуудын дундаж оролцоо “огт үгүй” гэсэн хариулт руу дөхжээ. Өмнөх хэсэгт, залуучуудын улс төрийн оролцоог ангилж, дунджаар тооцоход “огт үгүй” гэсэн хариулт давамжгайлж байсан билээ. Өөрөөр хэлбэл, улс төрийн оролцооны дундажийг бууруулж байсан хариулт нь ямар нэгэн улс төрийн статусгүй залуучуудын хариулт байв.

Зураг 35. Сонгуульд оролцох чухал эсэх, улс төрийн статусаар



Судалгаанд оролцсон дийлэнх залуучуудын хувьд сонгуульд оролцох нь “маш чухал” гэсэн хариултыг өгч байсан. Ялангуяа улс төрийн намын гишүүн залуучуудын 98 хувь нь сонгуулийн оролцоог “маш чухал”, “чухал” гэж дүгнэжээ.



Зураг 36. Сонгуулийн ухуулагчаар ажиллаж байсан эсэх, улс төрийн статусаар




Сонгуульд ухуулагчаар ажиллах нь улс төрийн статустай буюу улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын гишүүн эсэхтэй өндөр хамааралтай байна. Улс төрийн статустай 100 залуугийн 42 нь сонгуульд ухуулагчаар ажиллаж байсан бол ямар нэгэн улс төрийн статусгүй залуучуудын хувьд тухайн хувь 24 болж буурч байна.

Судалгааны өмнөх хэсэг буюу хоёрдугаар бүлэгт, сонгуульд ухуулагчаар ажиллаж байсан залуучуудын дунд "эргэлзэж байгаа ч тухайн ухуулагчаар ажилласан намдаа санал өгсөн" гэсэн хариултын хувь өндөр байсан билээ. Эндээс дүгнэхэд, ямар нэгэн улс төрийн статустай залуучууд сонгуульд ухуулагчаар ажиллах нь харьцангуй түгээмэл бөгөөд эдгээр залуучууд тухайн ажилласан намдаа саналаа өгөх нь харьцангуй өндөр байна.

Сонгуулийн мэдээллийн хүртээмж улс төрийн статусаас хамааран ялгаатай байв. Улс төрийн мэдээллийг сонгуулийн санал авах өдөртэй холбоотой, нэр дэвшигчтэй холбоотой, санал өгөх явц, шийдвэр гаргалттай холбоотой хэмээн 3 ангилж, мэдээллийг их, бага ямар нэгэн хэмжээгээр хүлээн авдаг хэсгийг Зураг 37-39-д тусгалаа. Эндээс аль ч төрлийн улс төрийн мэдээллийн хувьд улс төрийн статустай залуучуудын тухайн мэдээллийг хүлээн авч буй хувь өндөр байлаа.

Зураг 37. Сонгуулийн санал авах өдөр, бүртгэлтэй холбоотой мэдээлэл, улс төрийн статусаар



Сонгуулийн санал авах өдөр, сонгуулийн тойргийн хуваарилалт, тухайн өдөр хаана очиж саналаа өгөх, сонгогчийн бүртгэлтэй холбоотой, саналаа өгөхдөө ямар бэлтгэлтэй очих зэрэг мэдээллүүдийн хувьд улс төрийн статусаас хамааран тухайн мэдээллүүдийг хүлээн авах байдал 10-23 хувиар зөрүүтэй байв.

Зураг 38. Нэр дэвшигчтэй холбоотой мэдээлэл олж авах байдал, улс төрийн статусаар




Харин нэр дэвшигчдийн талаарх болон тэдний мөрийн хөтөлбөртэй холбоотой мэдээллүүдийн хувьд улс төрийн статусаас хамааран 13-20 хувийн зөрүүтэй буюу өмнөх асуулттай харьцуулахад зөрүү харьцангуй буурсан.

Зураг 39. Санал өгөх үйл явц ба шийдвэр гаргалтын мэдээлэл, улс төрийн статусаар



Санал өгөх үйл явц, сонгуулийн хууль бус зүйлсийн талаар, саналаа өөрөө бие даан гаргах, сонгуулийн амлалт, сонгуулийн сурталчилгаа, түүний үйл явцын талаарх мэдээлэл нь улс төрийн статустай залуучуудын тухайн мэдээллүүдийг хүлээн авах байдал харьцангуй өндөр буюу 14-24 хувийн зөрүүтэй байна.

Зураг 40. Нийт улс төрийн мэдээллийн хүртээмж, дундаж




Улс төрийн мэдээллүүдийн хүртээмжийг ерөнхийд нь дүгнэхэд улс төрийн статустай залуучууд улс төрийн статусгүй залуучуудтай харьцуулахад бүх төрлийн улс төрийн мэдээллийг “маш сайн”, “сайн” авдаг нь харагдаж байна.

3.2 СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД УХУУЛАГЧААР АЖИЛЛАЖ БАЙСАН ЭСЭХЭЭС ХАМААРСАН ХАМААРАЛ


Судалгааны энэ хэсэгт залуучуудын (17-26 нас) сонгуульд ухуулагчаар ажиллаж байсан болон 2021 онд болох Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд ажиллаж байгаа залуучуудын хүйс, нас, амьдарч буй байршлын хамаарлыг шинжлэв. Судалгаанд оролцсон залуучуудын 27.6 хувь нь сонгуульд ухуулагчаар ажиллаж байжээ.

Зураг 41. Ухуулагчаар ажиллаж байсан эсэх, хүйсээр




Судалгаанд оролцсон 17-26 насны эмэгтэйчүүдийн 28 хувь, эрэгтэйчүүдийн 30 хувь нь ухуулагчаар ажилласан байна. Сонгуулийн ухуулагчаар ажиллах нь хүйсийн хувьд харьцангуй тогтвортой байв.

Зураг 42. Ухуулагчаар ажиллаж байсан эсэх, насаар



Сонгуулийн сурталчилгаанд ухуулагчаар ажилласан залуучууд насны хувьд 19-24 насныхан байна. Тухайлбал, судалгаанд оролцсон 19-22 насны залуучуудын 36 хувь нь, 23-24 насны залуучуудын 30 хувь нь сонгуулийн сурталчилгаанд ухуулагчаар ажилласан байсан. Харин 18 нас хүрсэн залуучууд сонгуульд ухуулагчаар ажиллаж болох учраас 17-18 насны залуучуудын 6 хувь нь ухуулагчаар ажилласан байх магадлалтай.

Зураг 43. Ухуулагчаар ажиллаж байсан эсэх, байршлаар




Судалгаанд оролцсон орон нутагт амьдардаг залуучуудын 39 хувь нь сонгуулийн сурталчилгаанд ухуулагчаар ажиллаж байсан нь Улаанбаатар хотод амьдардаг залуучуудтай харьцуулахад 17 хувиар илүү үзүүлэлтэй байв.

3.3 СОНГУУЛИЙГ ЧУХАЛЧИЛДАГ ЭСЭХИЙН ХАМААРАЛ

Судалгааны энэ хэсэгт залуучууд (17-26 нас) сонгуулийг “маш чухал”, “чухал” гэж бодоход юу нөлөөлдөг, энэ нь эргээд сонгогчдын зан төлөвт хэрхэн нөлөөлөхийг судлав.


Зураг 44. Сонгуулийг чухалчилдаг эсэх, хүйсээр

■ Сонгууль маш чухал, чухал ■ Сонгууль чухал биш




Зураг 46. Сонгуулийг чухалчилдаг эсэх, байршлаар

■ Сонгууль маш чухал, чухал ■ Сонгууль чухал биш



Зураг 45. Сонгуулийг чухалчилдаг эсэх, насаар




Сонгуулийг чухалчилдаг эсэх нь нас, хүйс, байршлаас үл хамааран судалгаанд оролцогч залуучуудын 90-ээс дээш хувь нь сонгуулийг “маш чухал”, “чухал” гэж үзжээ.

Хүснэгт 11. Сонгуулийг чухалчилдаг эсэх, сонгууль өгөх давтамж

	Сонгуульд байнга оролцдог хүний сонгуулийн тухай бодол		Сонгуулийг чухал гэж боддог хүний сонгууль өгөх давтамж	
	Байнга	Бусад	Байнга	Бусад
Маш чухал, чухал	98%	87%	70%	30%
Чухал биш	2%	13%	28%	72%


Оролцогч сонгуулийг чухал гэж бодсоноор сонгуульд оролцох давтамж нэмэгддэг байх боломжтой. Нөгөө талаас, сонгуульд саналаа тогтмол өгдөг хүний сонгуульд өгөх ач холбогдол өөрчлөгдсөн байх ч боломжтой юм. Тэгвэл сонгуульд байнга саналаа өгдөг сонгогчийн хувьд “хааяа оролцдог”, “оролцдоггүй” сонгогчтой харьцуулахад сонгуульд саналаа өгдөг гэсэн ач холбогдол нь өндөр байсан. Харин сонгуульд саналаа өгөх нь “маш чухал”, “чухал” гэж үздэг оролцогчдын хувьд сонгуульд тогтмол оролцдог байна.

Зураг 47. Сонгуулийг чухалчилдаг эсэх, сонгуульд оролцож саналаа өгөх эсэх



Судалгааг 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын өмнө авсан тул удахгүй болох сонгуульд оролцох хандлагыг энд харьцууллаа. Сонгуульд санал өгөх нь маш чухал, чухал гэж үздэг залуучуудын хувьд 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх хувь харьцангуй өндөр байв.

Зураг 48. Сонгуулийг чухалчилдаг эсэх, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог байдал




Ойр дотны хүмүүстэй улс төрийн талаар үзэл бодлоо солилцдог залуучуудын хувьд сонгуулийг маш чухал, чухал хэмээн үздэг нь илүү байна.



3.4 СОНГУУЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ АВДАГ БАЙДЛЫН ХАМААРАЛ


Судалгааны энэ хэсэгт 17-26 насны Z үеийн залуучуудын сонгуулийн санал өгөх өдөр, үйл явц, нэр дэвшигч, мөрийн хөтөлбөр зэрэг олон төрлийн мэдээллийг авах байдлын хамаарлыг шинжлэв. Ингэхдээ улс төрийн талаарх мэдээлэл “маш сайн” авдаг, “сайн” авдаг гэсэн хариултыг мэдээлэл сайн авдаг гэж дүгнэсэн болно.

Зураг 49. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, насаар



Судалгаанд оролцогч 17-18 насныхан сонгуулийн талаарх мэдээллийг харьцангуй муу авдаг бол 19-26 насны залуучуудын 67-74 хувь нь сонгуульд санал өгөхтэй холбоотой мэдээллүүдийг сайн авдаг гэжээ.

Зураг 50. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, хүйс, байршлаар



Сонгуулийн талаарх мэдээлэл авах байдлыг судалгаанд оролцогчийн хүйс, байршил болон улс төрийн оролцооноос хамааруулан харвал, энэ төрлийн мэдээлэл авч байгаа эсэх нь хүйс, байршил зэрэг үзүүлэлтээс харьцангуй бага хамааралтай байна.

Зураг 51. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, улс төрийн оролцоогоор



Улс төрд байнга оролцдог гэж хариулсан оролцогчдын 91 хувь нь сонгуульд санал өгөхтэй холбоотой мэдээлэл сайн авдаг гэжээ. Эндээс улс төрийн оролцоо нэмэгдэх тусам энэ төрлийн мэдээллийг хүлээн авах байдал харьцангуй сайн байна.

Зураг 52. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, сонгуульд санал өгдөг эсэх



Сонгуульд оролцож, саналаа өгсөн оролцогчид саналаа өгөхтэй холбоотой мэдээллийг харьцангуй сайн авдаг гэжээ. Харин сонгуульд оролцох насанд хүрсэн ч санал өгч байгаагүй залуучуудын хувьд сонгуулийн талаарх мэдээллийг сайн эсвэл муу авдаг эсэх нь тус бүр ойролцоогоор 50 хувь байв.

Зураг 53. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх эсэх



Тун удахгүй болох сонгуульд оролцож саналаа өгөх эсэх нь сонгуулийн талаарх мэдээллийг сайн авдаг эсэхээс хамааралтай байгааг эндээс харж болно. Тодруулбал, сонгуулийн талаарх мэдээлэл сайн авдаг залуучуудын 87 хувь нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож, саналаа өгнө гэсэн бол сонгуулийн талаарх мэдээлэл дутмаг байгаа оролцогчдын 67 хувь нь саналаа өгнө гэжээ.

Зураг 54. Сонгуулийн талаарх мэдээллийг авдаг байдал, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог эсэх



Ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог залуучуудын 75 хувь нь сонгуулийн талаар харьцангуй сайн мэдээлэл авдаг байна. Харин ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдоггүй залуучуудын 55 хувь нь сонгуулийн талаарх мэдээллийг сайн авдаг гэж хувь буурч байна.

3.5 СОНГУУЛЬД САНАЛ ӨГӨХДӨӨ ЧУХАЛЧИЛДАГ ЗҮЙЛСИЙН ХАМААРАЛ

Судалгааны энэ хэсэгт 17-26 насны Z үеийн залуучуудын сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг зүйлсэд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг шинжлэв. Хариултыг бүлэглэхдээ тухайн үзүүлэлтийг “маш чухал”, “чухал” гэсэн хариултын нийт хариултад эзлэх хувиар тооцсон болно.

Хүснэгт 12. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг/чухалчлах хүчин зүйлс, насаар

	17 - 18 настай	19 - 22 настай	23 - 24 настай	25 - 26 настай
Нэр дэвшигчийг чухалчилдаг	53%	68%	78%	83%
Дэмждэг нам, эвслийг чухалчилдаг	13%	14%	12%	14%
Гэр бүл, ойр дотны хүмүүсийн саналыг харгалздаг	13%	10%	8%	11%
Найз нөхөд, ангийнхны саналыг харгалздаг	2%	3%	2%	0%
Цахим орчинд өрнөж буй хандлага, олон нийтийн саналыг харгалздаг	12%	12%	12%	10%
Сонгуулийн өмнөх улс төрийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэж сонголтоо хийдэг	34%	38%	40%	29%
Мөрийн хөтөлбөрийг нь уншиж танилцан, сонголтоо хийдэг	46%	55%	55%	46%

Судалгаанд оролцсон залуучуудын дийлэнх буюу 53-83 хувь нь сонгуульд нэр дэвшигч хэн байгааг чухалчилдаг байна. Оролцогчдын нас нэмэгдэхийн хэрээр нэр дэвшигчийг чухалчлах байдал нэмэгдсэн хамаарал ажиглагдлаа. Залуучууд сонголт хийхдээ найз нөхөд, гэр бүл, дэмждэг нам эвсэл, цахим орчин дахь олон нийтийн хандлага гэхээс илүүтэй нэр дэвшигч, мөрийн хөтөлбөр болон өмнөх амлалтын биелэлтийг чухалчилж байгаа нь сайшаалтай байв.

Зураг 55. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг хүчин зүйлс, хүйсээр



Сонгогч хүйсээс үл хамааран сонголтод чухалчилдаг хүчин зүйлс харьцангуй тогтвортой байлаа.

Зураг 56. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг хүчин зүйлс, байршлаар



Улаанбаатар хотод амьдарч буй залуучуудын хувьд сонгуульд санал өгөхдөө нэр дэвшигч болон дэмждэг улс төрийн нам, эвслийг чухалчлах хандлага орон нутагт амьдарч буй залуучуудаас бага зэрэг илүү байлаа.

Хүснэгт 13. Сонгуульд санал өгөхдөө чухалчилдаг хүчин зүйлс, гэр бүл ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал сонилцдог эсэх

	Гэр бүл, ойр дотны хүмүүстэйгээ санал солилцдог	Гэр бүл, ойр дотны хүмүүстэйгээ санал солилцдоггүй
Нэр дэвшигчийг чухалчилдаг	69%	64%
Дэмждэг нам, эвслийг чухалчилдаг	14%	9%
Гэр бүл, ойр дотны хүмүүсийн саналыг харгалздаг	10%	15%
Найз нөхөд, ангийнхны саналыг харгалздаг	2%	2%
Цахим орчинд өрнөж буй хандлага, олон нийтийн саналыг харгалздаг	12%	10%
Сонгуулийн өмнөх улс төрийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэж сонголтоо хийдэг	38%	25%
Мөрийн хөтөлбөрийг нь уншиж танилцан, сонголтоо хийдэг	54%	40%

Судалгаанд оролцсон гэр бүл, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог болон солилцдоггүй залуучуудын дийлэнх буюу 64-69 хувь нь сонгуульд нэр дэвшигч хэн байгааг чухалчилдаг гэсэнд төдийлөн зөрүү байсангүй. Харин гэр бүл, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог залуучууд сонгуульд санал өгөхдөө мөрийн хөтөлбөрийг нь уншиж танилцан, сонголтоо хийдэг, дэмждэг улс төрийн нам, эвслийг чухалчилдаг гэсэн хариултуудын хувь гэр бүл, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдоггүй залуучуудын хариултаас өндөр байв. Сонирхолтой нь ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар үзэл бодлоо солилцдог залуучууд шийдвэр гаргахдаа эдгээр хүмүүсийн саналыг харьцангуй бага харгалздаг байна.

3.6 СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ УНШДАГ ЭСЭХИЙН ХАМААРАЛ


Судалгааны энэ хэсэгт 17-26 насны Z үеийн залуучууд сонгуульд сонголт хийх шийдвэр гаргахдаа мөрийн хөтөлбөрийг уншиж танилцаж буй байдал нь нас, хүйс, байршил болон ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог эсэхээс хэрхэн хамаарч байгааг шинжлэв.

Хүснэгт 14. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншдаг эсэх, насаар

	17 - 18 настай	19 - 22 настай	23 - 24 настай	25 - 26 настай
Сонгуулийн мөрийн хөтөлбөртэй эртнээс уншиж танилцан, сонголтоо хийдэг	35%	40%	33%	21%
Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тойм байдлаар багцалсан мэдээллийг харж сонголтоо хийдэг	26%	38%	53%	57%
Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг гүйцэд уншдаггүй, халт танилцаад сонголтоо хийдэг	7%	8%	4%	8%
Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаггүй, нэр дэвшигчийн өөр бусад зүйлсийг харж сонголтоо хийдэг	2%	4%	7%	5%
Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаггүй, гэр бүл ойр дотныхны санал болгож зөвлөсний дагуу сонголтоо хийдэг	2%	3%	1%	2%
Хэлж мэдэхгүй байна	28%	7%	2%	7%


Судалгаанд оролцсон аль ч насны залуучуудын хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөртэй сайн танилцах эсвэл тойм байдлаар танилцан сонголтоо хийх хандлага давамгайлжээ. Харин судалгаанд оролцсон залуучуудын нас нэмэгдэхийн хэрээр сонгуулийн мөрийн хөтөлбөртэй эртнээс сайтар танилцах байдал буурч, тойм мэдээг илүүд үзэх хандлагатай байв. 17-18 насны залуучуудын 28 хувь нь мөрийн хөтөлбөртэй холбоотой эдгээр асуултуудад “хэлж мэдэхгүй байна” гэж хариулсан нь бусад насны залуучуудын хариулттай харьцуулахад хамгийн өндөр хувь байна.

Зураг 57. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншдаг эсэх, хүйсээр



Судалгаанд оролцсон залуучууд сонгуулийн мөрийн хөтөлбөрийг унших байдалд хүйсийн ялгаа бага байлаа.

Зураг 58. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг эсэх, байршлаар




Судалгаанд оролцсон залуучуудын амьдарч буй байршил мөрийн хөтөлбөртэй танилцах байдалд бараг нөлөөгүй байсан. Гэхдээ Улаанбаатар хотод амьдардаг залуучуудын хувьд мөрийн хөтөлбөрийн тоймтой танилцаж, шийдвэр гаргах байдал давамгайлж байсан бол орон нутагт амьдардаг залуучуудын хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөртэй эртнээс уншиж, танилцан, шийдвэрээ гаргах байдал давамгайлжээ.

Дээрхээс гадна, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог залуучуудын 80 хувь нь мөрийн хөтөлбөртэй ямар нэг байдлаар танилцсан байдаг бол улс төрийн талаар санал солилцдоггүй залуучуудын 55 хувь нь л мөрийн хөтөлбөртэй танилцдаг, 29 хувь нь хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн.

3.7 2021 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЭСЭХИЙН ХАМААРАЛ


Судалгааны энэ хэсэгт 2021 оны 6 сард болох Ерөнхийлөгчийн сонгуульд 17-26 насны Z үеийн залуучуудын оролцоонд нөлөөлөх боломжит хүчин зүйлсийг судаллаа.

Зураг 59. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгөх эсэх, нас, хүйс, байршлаар




Ерөнхийдөө 17-18 насны залуучуудын хувьд сонгуулийн нас болоогүй эсвэл бусад шалтгааны улмаас сонгуульд санал өгөх хувь харьцангуй бага байсан бол судалгаанд хамрагдсан 19-24 насны залуучуудын 88-89 хувь нь сонгуульд санал өгнө гэжээ. Сонгуульд эмэгтэй болон орон нутагт амьдардаг залуус оролцоно гэсэн хариултыг илүүтэй өгсөн.

Зураг 60. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эсэх, сонголтод чухалчилдаг хүчин зүйлс



Сонголтоо хийхдээ харгалздаг хүчин зүйл цаашид оролцох сонгуулийн зан төлөвт нөлөөлж байгаа эсэхийг харуулав. Залуучууд сонголтоо хийхдээ ямар зүйлсийг харгалздагаас үл хамааран 75-85 хувь нь сонгуульд оролцож саналаа өгнө гэжээ. Эдгээрээс цахим орчинд өрнөж буй хандлагыг чухалчилж сонголтоо хийдэг залуучуудын сонгуулийн оролцоо харьцангуй бага байгаа бол мөрийн хөтөлбөр болон нам, эвслийг чухалчилдаг залуучуудын хувьд оролцоо өндөр байх нь харагдлаа.

Зураг 61. Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эсэх, мөрийн хөтөлбөр уншиж танилцдаг байдал



Мөрийн хөтөлбөртэй танилцалгүй, ойр дотны хүмүүсийн зөвлөгөөнд үндэслэн сонголт хийдэг залуучуудын 69 хувь нь удахгүй болох сонгуульд оролцоно гэсэн бол мөрийн хөтөлбөртэй их, бага ямар нэг хэмжээгээр танилцдаг эсвэл танилцаагүй ч нэр дэвшигчийн бусад зүйлсийг харгалзан сонголт хийдэг залуучуудын оролцоо 75 хувиас дээш байхаар байлаа.

Мөн сонгуулийн оролцоонд ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог эсэх нь нөлөөлж байж болох юм. Тодруулбал, улс төрийн талаар санал солилцдог бүлгийн 83 хувь нь сонгуульд оролцохоо илэрхийлсэн бол улс төрийн талаар санал солилцдоггүй бүлгийн ердөө 62 хувь нь сонгуульд оролцоно гэжээ.

3.8 УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ БАЙДЛЫН ХАМААРАЛ


Судалгааны энэ хэсэгт 17-26 насны Z үеийн залуучууд 7 хоног бүр 1 болон түүнээс дээш эсвэл өдөр тутам улс төрийн мэдээлэл авдаг сувгуудыг харьцуулж, нас, хүйс, байршил зэргээс хамаарч байгаа эсхийг шинжлэв.

Хүснэгт 15. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, насаар


	17 - 18 настай	19 - 22 настай	23 - 24 настай	25- 26 настай
ТВ	62%	71%	67%	75%
Сонин, сэтгүүл	27%	36%	39%	34%
Мэдээллийн сайтууд	67%	74%	81%	78%
ФМ, радио	20%	31%	29%	20%
Фэйсбүүк	75%	80%	80%	87%
Твиттер	24%	36%	37%	36%
Инстаграм	37%	35%	37%	30%
Youtube	28%	28%	32%	25%
Tik Tok	10%	13%	16%	14%
Гэр бүл	56%	59%	59%	55%
Найз нөхөд	43%	51%	50%	51%
Багш	34%	38%	33%	22%

Судалгаанд хамрагдсан бүх насны оролцогчдын хувьд Фэйсбүүкээр дамжуулан улс төрийн мэдээлэл авах байдал харьцангуй өндөр байсан бол Tik Tok, ФМ, радио болон сонин сэтгүүлээр дамжуулан мэдээлэл авах байдал бага байсан. Аль ч насны бүлгээс үл хамааран Фэйсбүүк, мэдээллийн сайтууд болон телевиз нь улс төрийн мэдээллийн гол эх үүсвэр болдог байна.

Зураг 62. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, хүйсээр




Зураг 63. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, байршлаар



Улс төрийн талаарх мэдээлэл хүлээн авах суваг Улаанбаатар хот болон орон нутагт ерөнхийдөө ижил байна. Гэхдээ Улаанбаатар хотоос судалгаанд оролцсон залуучуудын 83 хувь нь инстаграмаар энэ төрлийн мэдээлэл 7 хоногтоо дор хаяж нэг удаа авдаг гэсэн бол орон нутагт энэ хувь 40 болж, даруй 43 хувиар буурч байна. Иймд улс төрийн талаарх мэдээллийг орон нутагт түгээх бол инстаграм хаяг ашиглах нь үр дүн багатай байж болох юм.

Зураг 64. Долоо хоног тутам улс төрийн талаарх мэдээлэл авдаг сувгууд, ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог эсэх




Ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог залуучууд аль ч мэдээллийн сувгаар улс төрийн талаарх мэдээллийг илүү авдаг гэж хариулжээ.

3.9 ОЙР ДОТНЫ ХҮМҮҮСТЭЙГЭЭ УЛС ТӨРИЙН ТАЛААР САНАЛ СОЛИЛЦДОГ БАЙДЛЫН ХАМААРАЛ


Судалгаанд оролцсон залуучууд ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцох нь оролцогчдын сонголт болон улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж буйг өмнө дурдсан билээ.

Харин судалгааны энэ хэсэгт улс төрийн талаар үзэл бодлоо солилцож буй 17-26 насны Z үеийн залуучуудад тодорхой нийтлэг шинж байгаа эсэхийг шинжлэв.

Зураг 65. Улс төрийн талаар санал солилцдог бүлэг, насаар




Зураг 66. Улс төрийн талаар санал солилцдог бүлэг, хүйс, байршлаар



Ерөнхийдөө нас, хүйс болон оролцогчийн байршлаас үл хамааран ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог залуучууд нийт залуучуудын 85-89 хувийг эзэлж байв. Судалгаанд оролцогч 17-18 настай тохиолдолд энэхүү хувь хэмжээ буурч, 76 хувь болсныг онцлох нь зүйтэй.

Зураг 67. Ойр дотны хүмүүстэй улс төрийн талаар мэдээлэл солилцдог байдал, мэдээллийн хүртээмжээр



Судалгаанд оролцсон залуучууд ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаарх мэдээлэл солилцдог байх тусмаа энэ төрлийн мэдээллийг хүртээмжтэй гэж дүгнэжээ. Тодруулбал, улс төрийн талаарх мэдээлэл солилцдог залуучуудын 40 хувь нь улс төрийн мэдээллийг хүртээмжтэй гэж хариулсан бол бусад залуучуудын 25 хувь мөн адил хариулт өгсөн.




3.10 УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ СОНИРХОХ БАЙДЛЫН ХАМААРАЛ

Судалгааны энэ хэсэгт залуучууд (17-26 нас) өдөр тутмын улс төрийн үйл явдал, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас гаргаж буй зарлиг, шийдвэр зэргийг сонирхох түвшинг тодорхойлсон билээ. Энэхүү хэсэгт залуучуудын улс төрийн мэдээлэл сонирхох ерөнхий түвшинг “маш их сонирхдог”, “ер нь сонирхдог”, “хааяа сонирхдог” нөхцөлд улс төрийн мэдээллийг сонирхдог, үүнээс бага бол сонирхдоггүй гэж ангилсан.


Эндээс улс төрийн талаарх мэдээллийг сонирхох байдалд судалгаанд оролцсон залуучуудын хувийн онцлог болон улс төрийн мэдээллийн хүртээмж нөлөөлж байгаа эсэхийг шинжлэв.

Зураг 68. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог эсэх, мэдээллийн хүртээмжээр




Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдоггүй залуучуудын хувьд энэ төрлийн мэдээллийг хүртээмжгүй, мэдэхгүй гэх хариулт илүү давамгайл байгаа бол эсрэгээрээ улс төрийн мэдээлэл сонирхдог залуучууд энэ төрлийн мэдээллийг хүртээмжтэй гэж дүгнэв.

Зураг 69. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог эсэх, насаар



Улс төрийн талаарх мэдээллийг 19-22 насныхан илүү сонирхдог буюу насаар ангилбал улс төрийн талаарх мэдээлэл сонирхох байдал нь доошоо харсан U муруй хэлбэртэй байна.

Зураг 70. Улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог эсэх, хүйсээр




Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 68 хувь, эрэгтэйчүүдийн 63 хувь нь улс төрийн талаарх мэдээллийг сонирхдог. Эрэгтэй оролцогчидтой харьцуулахад эмэгтэйчүүд улс төрийн талаарх мэдээллийг илүүтэй сонирхдог байна.

3.11 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ УЛС ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ БАЙДЛЫН ХАМААРАЛ

Судалгааны энэ хэсэгт залуучууд (17-26 нас) цахим орчинд улс төрийн талаарх мэдээлэл гарсан тохиолдолд үзүүлэх хариу үйлдэл, үүнд нөлөөлж буй хүчин зүйлийг шинжлэхийг зорив. Хариу үйлдлийг “тогтмол орж уншдаг, сонирхолтой сэдэв байвал уншдаг, ямар хуудсанд гарснаас хамааран үзэх эсэхээ шийддэг, улс төрийн талаарх мэдээлэл сонирхдоггүй” хэмээн боловсруулсан болно.

Зураг 71. Цахим орчинд гарсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл, насаар




Насны бүлгээс үл хамааран дийлэнх оролцогчид мэдээллийн эх сурвалжийг харж, унших эсэхээ шийддэг гэжээ. Эндээс 17-18 болон 25-26 насны залуучууд бусад бүлэгтэй харьцуулахад сонирхолтой мэдээлэл байвал уншдаг бол 19-24 насны залуучууд эх сурвалжийг шалгаж мэдээлэл унших нь харьцангуй өндөр байна.

Зураг 72. Цахим орчинд гарсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл, хүйсээр



Цахим орчинд гарсан улс төрийн талаарх мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл нь хүйсээс төдийлөн хамаарахгүй байгаа боловч эмэгтэйчүүд мэдээллийн эх сурвалжийг нягтлах, эрэгтэйчүүд сонирхолтой сэдэв байвал унших нь харьцангуй өндөр байлаа.

Зураг 73. Цахим орчинд гарсан мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл, байршлаар




Цахим орчинд гарсан улс төрийн талаарх мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл нь судалгаанд оролцогчийн амьдарч буй байршлаас хамаарах тодорхой холбоо ажиглагдаагүй. Гэхдээ Улаанбаатар хотод амьдардаг залуучуудын 8 хувь нь улс төрийн мэдээг тогтмол уншдаг гэсэн бол орон нутагт харьцангуй өндөр буюу 15 хувь байв.

3.12 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО


Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын (17-26 нас) улс төрийн оролцоо, сонгуулийн оролцоо, улс төрийн талаарх мэдээллийг хүлээж авах байдал зэргийг шинжлэв. Судалгаанд оролцсон залуучуудын 3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй залуучууд байв.

Зураг 74. Улс төрийн оролцоо



Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй залуучууд хөгжлийн бэрхшээлгүй залуучуудтай харьцуулахад өөрсдийнхөө улс төрийн оролцоог бага гэж дүгнэсэн байна. Улс төрд “огт оролцдоггүй”, “хэлж мэдэхгүй байна” гэсэн хариултыг хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 40 хувь нь өгсөн бол хөгжлийн бэрхшээлгүй залуучуудын хувьд 28 хувь болон буурч байгаа юм.

Зураг 75. Сонгуулийг чухалчилдаг байдал




Сонгуулийг чухалчлах хандлага хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад хөгжлийн бэрхшээлгүй залуучуудтай харьцуулахад бага байв. Эдгээр залуучуудын 19 хувь нь сонгууль “нэг их чухал биш”, “чухал биш”, “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн бол хөгжлийн бэрхшээлгүй залуучуудын ердөө 5 хувь нь ийм дүгнэлт хийсэн.

Зураг 76. Сонгуульд оролцож санал өгч байсан эсэх



Сонгуульд оролцох хувь хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй залуучуудын хувьд бараг ялгаагүй байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 81 хувь нь, хөгжлийн бэрхшээлгүй залуучуудын 78 хувь нь сонгуульд оролцож саналаа өгч байжээ.

Зураг 77. 2020 онд болж өнгөрсөн сонгуулиуд шударга, зөв болсон эсэх



Сонгуулийг шударга, зөв болсон гэх хандлага нийт залуучуудын дунд харьцангуй бага байсан билээ.

Зураг 78. Сонгуулийн мөрийн хөтөлбөр уншиж, танилцдаг эсэх



Сонгуулийн мөрийн хөтөлбөр унших, танилцах байдал хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дунд харьцангуй бага байна. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлгүй залуучуудын 86 хувь нь мөрийн хөтөлбөртэй “эртнээс уншиж танилцдаг”, “багцалсан мэдээг уншдаг” бол хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын 70 хувь нь эдгээр хариултыг сонгожээ.

Зураг 79. Цахим орчинд гарсан улс төрийн талаарх мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл



Цахим орчинд гарсан улс төрийн талаарх мэдээлэлд үзүүлэх хариу үйлдэл судалгаанд оролцсон залуучуудын дунд ерөнхийдөө ижил байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй залуучууд улс төрийн талаарх сонирхолтой мэдээллийг унших, эх сурвалжийг нягтлан шийдвэр гаргах хандлага харьцангуй өндөр байв.

Зураг 80. Улс төрийн мэдлэг, клуб зэрэгтэй холбоотой мэдээлэл



Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хувьд цаашид улс төрийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх хүсэл 68 хувь буюу хөгжлийн бэрхшээлгүй залуучуудын хариулсан хувиас харьцангуй бага байна. Улс төрийн талаарх мэдлэг оролцоогоо дээшлүүлэх сайн дурын клубт нэгдэх бодол 57 хувь буюу бага байна. Харин найз нөхөд, гэр бүл буюу ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаарх санал солилцдог хувь ойролцоо байлаа.

4



ДҮГНЭЛТ

17-26 насны залуучуудын улс төрийн сонирхол, оролцоо, хандлагыг тодорхойлох зорилгоор хийсэн судалгааны хүрээнд дараах тойм дүгнэлтийг хийж байна.

- Судалгаанд хамрагдсан залуучуудын улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр нь сонгуульд оролцож саналаа өгөх байдлаар илэрч байна. Тэд сонгуультай холбоотой мэдээлэл, сонгуулийн үр дүнг хамгийн их сонирхдог, улс төрийг ерөнхийд нь “заримдаа” сонирхож, оролцдог боловч бодит оролцоо нь хязгаарлагдмал, өнөөгийн улс төрийг замбараагүй гэж үздэг байна.
- Залуучууд улс төрийг ерөнхийд нь сонирхох байдал өндөр хувьтай гарсан боловч улс төрийн талаарх ойлголт, мэдээллүүдийг нарийвчлан “сонирхдог” эсэхийг асуухад бага хувьтай хариулсан нь улс төрийн талаарх бүх ойлголт, сэдвүүдийг төдийлөн сонирхдоггүй, анхаардаггүйг илтгэж байсан.
- Залуучууд улс төрийн оролцоогоо ерөнхийлөн дүгнэх нь тухайн улс төрийн оролцооны хэлбэр тус бүрээр дүгнэснээс ялгаатай байсан юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн оролцооны хэлбэр бүрээр ангилан үнэлэхэд залуучуудын 59 хувь нь “огт оролцдоггүй” ангилалд хамаарагдсан. Цахим орчинд, ялангуяа фэйсбүүкээр өөрийн үзэл бодлоо илэрхийлж, улс төрийн талаарх мэдээлэлд лайк зэрэг эможи дарж хариу үйлдэл үзүүлэх улс төрийн оролцооны хэлбэрт “заримдаа оролцдог”, бусад улс төрийн оролцооны хэлбэрүүдэд “огт үгүй” гэсэн хариулт дийлэнх байлаа. Эндээс залуучууд өөрсдийгөө улс төрд хааяа оролцдог гэж боддог боловч сонгуульд саналаа өгөхөөс бусад үйл ажиллагаанд огт оролцдоггүй байдал давамгайлж байна.
- Судалгаанд оролцсон залуучуудын 95 хувь нь сонгуульд оролцох нь “маш чухал”, “чухал”, харин 80.2 хувь нь 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгнө гэж тус тус хариулсан. 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдөр болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд 18-19 насны залуучуудын 56.45 хувь, 20-24 насны залуучуудын 43.72 хувь, 25-29 насны залуучуудын 46.32 хувь нь саналаа өгчээ. Энэхүү судалгаанд оролцсон залуучууд “Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгнө” гэж 80.2 хувь нь хариулж байсан бол бодит байдал дээр дунджаар 48 хувь нь сонгуульд оролцож саналаа өгчээ. Сонгуульд оролцож саналаа өгөх нь чухал гэж хариулсан ч энэ насны залуучуудын сонгуулийн оролцоо бодит байдал дээр төдийлөн сайн биш байна.
- Залуучуудын нас нэмэгдэхийн хэрээр сонголт хийхдээ нэр дэвшигчийн онцлогийг харгалзах байдал өсдөг бөгөөд үүнд хүйсийн ялгаа ажиглагдаагүй. Улаанбаатар хотод амьдардаг эсвэл ойр дотны хүмүүстэйгээ улс төрийн талаар санал солилцдог залуучуудын хувьд шийдвэр гаргахдаа илүү олон зүйлийг чухалчилж үздэг байна.
- Сонгуулийн талаарх мэдээллийг ангилж, сонгогчдод хүрч буй хүртээмжийн талаар асуухад судалгаанд оролцогчдын 62 хувь нь “мэдээлэл маш сайн авдаг”, “мэдээлэл сайн авдаг” гэж хариулжээ. Сонгуулийн талаарх наад захын мэдээллүүдийг залуучууд олж авдаг гэдэг нь эндээс харагдаж байлаа. Гэхдээ зөвхөн сонгуулийн талаарх мэдээллээс бусад улс төрийн талаарх мэдээллүүдийг сонирхох байдал ерөнхийдөө хангалтгүй байна.

- Залуучууд сонгуулийн үеэрх нэр дэвшигчид болон намуудын мөрийн хөтөлбөрийг төдийлөн уншиж танилцдаггүй, зарим залуучуудын хувьд энэ талаарх ойлголт байхгүй учраас мөрийн хөтөлбөрийг сонирхдоггүй байдал ажиглагдсан.
- Залуучууд УИХ-ын сонгуулийн талаар Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулиас илүү мэддэг, анзаардаг байна. Гэхдээ УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх бүрэн, цэгцтэй, цогц мэдээллийг авч чаддаггүй тул сонголтоо хийхэд асуудал үүсдэг. Мөн Сонгуулийн тухай хууль, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн тойрог, нэр дэвшигчдэд ямар шаардлага тавьдаг зэргийг мэддэггүй учраас сонгуулийг төдийлөн тоодоггүй, саналаа өгдөггүй. Зарим талаараа нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл ойлгомжгүй, цахим сүлжээн дэх мэдээллийн урсгал хэт их байдаг учраас түүнийг сонирхдоггүй байна.
- Энэхүү судалгааг хийснээрээ зөвхөн судалгаа авах бус, 17-26 насны залуучуудад улс төрийн талаарх ойлголт, мэдлэг өгөх ач холбогдолтой байсан. Мөн нийгэм, улс төр, эрх зүйн салбараас бусад салбарын оюутан суралцагчдад энэ талын мэдээлэл шинэлэг байсан нь чанарын судалгааны явцад ажиглагдаж байсан.
- Улс төрийн ямар нэгэн статустай залуучууд улс төрийг харьцангуй илүү сонирхож, оролцож, улс төрийн талаарх мэдээллүүдийг сайн авч, сонгууль болон улс төрийн ач холбогдлыг илүү ойлгосон байдаг ажээ.

Энэ бүхнээс дүгнэхэд, залуучуудын сонгуулийн ирц, оролцоо хангалтгүй, шийдвэр гаргах түвшинд манлайлал хязгаарлагдмал байна. Залуучуудын хэрэгцээ шаардлага, хүсэл тэмүүлэлд илүү анхаарал хандуулж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход тэдний оролцоог хангах нэн шаардлагатай болоод байна.

Иймээс Сонгуулийн ерөнхий хороо, төрийн болон төрийн бус байгууллагууд, улс төрийн нам, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн удирдлага, багш, судлаачид залуучуудыг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийг нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцоход ашиглах боломж нээлттэй байгаа зэргийг бүрэн ашиглаж улс төрийн талаарх ойлголт, мэдлэгтэй, хариуцлагатай оролцоотой иргэн байхын ач холбогдлыг таниулах, сонгуульд идэвхтэй оролцохыг уриалах, идэвхжүүлэх, заах, үлгэрлэх зэргээр ажиллах нь чухал байна. Ялангуяа сонгуульд анх удаа оролцож байгаа, эсвэл оролцохгүй байгаа залуучуудад чиглэсэн улс төрийн болон сонгогчдын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, залуучуудын илүү идэвхтэй оролцоог хангах сайн дурын ажиллагааны бүтцийг сайжруулж, нийгэм - улс төрийн мэргэжлийн оюутнуудын оролцоог түлхүү нөлөөтэй байхаар оролцуулах, цаашлаад залуучуудаас бүрдсэн иргэний нийгмийн байгууллагуудын төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогод нөлөөлөх боломжийг олгох нэн шаардлагатай байна.

#Zvote